

## Агуулга

### Нэгдүгээр хэсэг

1. Товч танилцуулга
2. Ярилцлага авагч нарт зориулсан зөвлөмж
3. Ярилцлагыг хэрхэн зохион байгуулж, асуулгыг авах тухай

### Хоёрдугаар хэсэг

#### **Судалгааны асуулга, түүнийг хэрхэн асууж, нөхөх талаар**

##### **I. Өрхийн асуулга- ХХС-1**

1. NH - Хаягийн хэсэг
2. HL - Өрхийн ам бүлийн байдал
3. ED - Өрхийн гишүүдийн боловсролын байдал
4. WS - Ундны усны болон ариун цэврийн байгууламжийн хангамж
5. HC1 - Өрхийн зарим тодорхойлолтууд
6. OV- Өнчин хүүхдийн талаарх асуулга  
OV- Дэмжлэг, тусламж
7. CL - Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт
8. CD - Хүүхдийн хүмүүжил
9. DA - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
10. MM - Эхийн эндэгдэл
11. IH - Өрхийн орлого
12. SI - Иоджуулсан давсны хэрэглээ

##### **II. Эмэгтэйчүүдийн талаархи асуулга-ХХС-2**

1. WM- Хаягийн хэсэг
2. CM- Хүүхдийн эндэгдэл
3. MN-Эх нялхасын эрүүл мэнд
4. MA-Гэрлэлтийн талаарх мэдээлэл
5. CP-Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ
6. DV-Гэр бүлийн доторх хүчирхийллийн байдал
7. HA-ДОХ/ХДХВ өвчний талаарх мэдлэг

##### **III. Тав хүртэлх насны хүүхдийн талаархи асуулга- ХХС-3**

1. UF- Хаягийн хэсэг
2. BR. Хүүхдийн төрсний бүртгэл, сургуулийн өмнөх боловсрол олголт
3. CE. Хүүхдийн хөгжил
4. VA. "А" амин дэмийн хэрэглээ
5. BF. Эхийн сүүгээр хооллолт
6. CA. Хүүхдийн өвчлөл, эмчилгээ
7. IM. Вакцинжуулалт
8. AN. Хүүхдийн өсөлтийн үзүүлэлт

## **1. Товч танилцуулга**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 онд болох тусгай хуралдаанаар “Дэлхийн Хүүхдийн Тунхаглал”-ын хэрэгжилтийн явц, байдлын талаар хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан гишүүн орон бүрийн Засгийн газар үндэсний илтгэлээ бэлтгэж байна. Энэ илтгэлийг бэлтгэх ажлын хүрээнд манай улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, аж байдал, тэдний эрхийн хэрэгжилтийг гүнзгийрүүлэн судлах зорилгоор Үндэсний статистикийн газраас НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхэд хөгжил” судалгааг 2005-2006 онд явуулж байна.

Анхны “Хүүхэд хөгжил” судалгааг 1996 онд, хоёр дахь удаагийн судалгааг 2000 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр явуулсан бөгөөд энэ удаагийн судалгааг НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол Улсын Засгийн газар хамтран санхүүжүүлж байна.

Судалгааны энэхүү аргачлал, зааврыг уг судалгааг нийслэл, аймаг, орон нутагт явуулах судлаач, ярилцлага авагч болон статистикийн байгууллагын хариуцсан мэргэжилтэн нарт зориулав. Энэ зааварт зарим үзүүлэлтийн тодорхойлолт, судалгааны асуулгыг хэрхэн асууж, нөхөх, асуулгын хариултын үнэн зөв байдлыг хянах талаар тайлбарлаж тодруулахыг зорив. Мөн асуулгуудыг хэрхэн авах, хариултын үнэн зөв байдал, бүлэг хоорондын уялдаа, холбоог шалгах зарим заавар, чиглэлийн талаар өгүүлнэ.

## **2. Ярилцлага авагч нарт зориулсан зөвлөмж**

### **2.1 Асуулгын талаар**

Судалгааны ХХС-1 асуулгыг өрхийн тэргүүлэгчээс, эсхүл тухайн өрхийн талаар сайн мэдэх, насанд хүрсэн, энэ өрхийн гишүүн хэн нэгнээс асууна. Судалгааны ХХС-2 асуулганд 15-49 насны эмэгтэйчүүд, ХХС-3 асуулгад 5 хүртэлх насны хүүхдүүд хамрагдах ба асуулгыг хүүхдийн эх эсвэл асран хамгаалагч, асрагчаас авна.

Судалгаанд хамрагдвал зохих өрхийн жагсаалт, хаягийг багийн ахлагч нар гаргаж, ярилцлага авагч нарт өгнө. Харин ярилцлага авагч нар уг жагсаалтанд байгаа бүх өрхийг судалгаанд хамруулах үүрэгтэй.

Судалгаанд хамрагдвал зохих өрхөөс судалгаа авахаар очиход тухайн айл эзэнгүй буюу судалгаа өгөхөөс татгалзсан болон судалгааг бүрэн авч чадаагүй тохиолдолд судалгааны асуулгын хуудсанд заавал тэмдэглэл хөтлөж байна. Тэдгээр өрхүүдээс судалгааг дахин очиж авах, эсвэл судалгаанд өөр айл хамруулах талаар багийн ахлагч зааварчилгаа гаргана.

Судалгааг авч байх үед тухайн өрхийн 5 хүртэлх насны хүүхэд нь гэртээ байхгүй байвал хүүхдийн талаар холбогдох асуулгыг хүүхдийн эхээс (асрагчаас) авч, харин хүүхдийн

биеийг хэмжих боломжгүй учир `Хүүхдийн биеийн хэмжээ` гэсэн дэд бүлгийн асуулгыг нөхөлгүй орхино.

Нэг өрхөд хамрагдаж байгаа хэд хэдэн тусдаа гэр бүлүүдийг нэг өрх гэж тооцож тэнд байгаа бүх эмэгтэйчүүд /асран хүмүүжүүлэгчид/, хүүхдүүдийг асуулганд бүрэн хамруулна.

Асуултуудын холбогдох хариултуудыг түүний кодийн хамт бичсэн байгаа бөгөөд хариулагчийн хариулт нь асуулганд өгөгдсөн хариултын алинд нь хамаарахыг үндэслэн тодорхойлж, холбогдох хариултын кодыг дугуйлах буюу бичнэ. Зарим тохиолдолд хариултыг тодруулах зорилгоор тухайн асуулган дотор нь нэмэлт асуултыг тусгасан байгаа.

Судалгааны зарим асуултанд өгсөн хариултаас хамаарч дараагийн асуултыг асуулгүй орхиж тухайн бүлгийн өөр асуулт ( $\Rightarrow$  CD12.) эсвэл дараагийн бүлэг рүү очихыг ( $\Rightarrow$  Бүлэг HC) гэсэн тэмдгээр зааварчилсан байгаа. Иймээс тухайн асуултыг асуух шаардлагагүй тохиолдолд уг асуултыг зураасаар зурж тэмдэглэ. Энэ нь асуултыг асуухаа мартаагүй харин зориуд орхисон гэдгийг ахлагчдад мэдэгдэхийн зэрэгцээ цаашдын боловсруулалтын явцыг ойлгомжтой, тодорхой болгох ёстой.

### 3. Ярилцлагыг хэрхэн зохион байгуулж, асуулгыг авах тухай

Ярилцлага авагч нь ярилцлагыг энгийн бөгөөд чөлөөтэй хэлбэрээр хийхийн зэрэгцээ, судалгааны асуултыг асуух болон түүний хариултанд маш анхааралтай хандаж асуулгын маягыг нөхнө. Үүнд:

- Юуны өмнө тухайн асуулт бүрийн зорилгыг сайтар ойлгож, асуулт тавихдаа өөртөө маш итгэлтэй байх хэрэгтэй. Ингэснээр хариулагчийн өгсөн хариу нь асуултанд хэрхэн нийцэж буйг мэдэхэд танд тус дөхөмтэй байх болно.
- Асуултыг маяганд бичигдсэний дагуу асуу. Хариулагч ойлгохгүй, эсвэл буруу дутуу ойлгосон явдал мэдэгдвэл асуултын өөрчилөхөд асуулгын үг хэллэгийг бага зэрэг өөрчилж болох боловч асуулгын утгыг хэрхэвч алдуулж болохгүйг онцгой анхаар.
- Асуултыг маяганд өгөгдсөн дэс дарааллын дагуу асууна.
- Ярилцаж буй хүн хоёр асуултанд зэрэг хариулсан ч байсан бүх асуултыг нэг бүрчлэн асууна. Иймд бүх асуултыг нэг бүрчлэн асуух ёстой гэдгийг тайлбарлаж өг, Эсвэл "Дахин тодруулахад ... ", "Эргэж ярихад.." гэх мэтээр асуулт нэг бүрээр ярилцлагыг үргэлжлүүл.
- Ярилцаж буй хүнээ хүндэтгэж аль болохоор чөлөөтэй байлгахыг хичээ, харин түүний өгөх хариуг та өөрөө санаачлахгүй байхыг анхаарах хэрэгтэй. Тухайлбал асуулганд хариулж байгаа эмэгтэйд хүүхдийнхээ насыг санахад нь туслах хэрэггүй.
- Асуултыг алгасч болно гэж зааварчлаагүй бол (энэ тохиолдолд асуултыг дарж зурахаа мартаж болохгүй) хариуг заавал (аль нэг хариуг сонгож) тэмдэглэнэ. Хариултын оронд

ямар нэг тэмдэглэлгүй хоосон зай үлдээвэл судалгааны ажлыг цаашид дүгнэх, боловсруулахад бэрхшээл учруулна. Өөрөөр хэлбэл таныг уг асуултыг мартаж орхисон мэтээр ойлгож болох юм.

- Асуултын хариуг тухай бүр нь тэмдэглэ. Тухайн өрхөөс явахын өмнө судалгааны хариуг бүрэн гүйцэд, зөв нөхсөн эсэхийг дахин хянаж үзнэ.
- Ярилцлага өгсөн хүнд хамтран ажилласан явдалд талархал илэрхийл. Судалгааг тодорхой цаг хугацаанд авах ёстойг санаж хэтэрхий удаан ярилцахаас зайлсхийх хэрэгтэй.

### 3.1 Нийтлэг заалт

#### 3.1.1 Нямбай хувцасла.

Та цэвэр, нямбай энгийн хувцаслах хэрэгтэй. Таны хувцаслалт, гадаад үзэмж тань таны ярилцлага авах гэж буй хүмүүст Таны талаархи анхны сэтгэгдлийг төрүүлж, өөрөөр хэлбэл Та яаж хувцасласнаас уг ярилцлагын үр дүн хамаарна.

#### 3.1.2 Ярилцлага авагч буюу тоологч нарын үүрэг, анхаарах зүйл:

Судалгаа авах өрхөд тохиромжгүй үед (жишээлбэл хоолны цагаар нь) очихгүй байхыг хичээ. Ярилцах гэж буй хүний зав боломжыг харгалзан үзэж асуулга авахыг бод.

Та эхлээд нэрээ хэлж өөрийгөө танилцуулаад биеийн байцаалт `үнэмлэхээ` үзүүл. Судалгааны зорилго, мөн өрхийн эмэгтэйчүүдтэй чухам яагаад ярилцах болсоны учрыг зааврынхаа дагуу тайлбарлаж өг.

Хувь хүний болон Статистикийн тухай Монгол улсын хуулийн дагуу судалгаанд хамрагдагчдын талаархи мэдээллийн нууцыг хадгална гэдгийг тайлбарлаж, асуулганд хариу өгөх сонирхолгүй байгаа хүнийг ярилцлагад татан оролцуулах талаар зохих бэлтгэлтэй байх хэрэгтэй.

Чухам ямар үндсэн шалтгаанаас болоод судалгаанд хамрагдахаас татгалзаж байгааг тэмдэглэж авна.

Та ажил үүргээ гүйцэтгэх бүхий л хугацаандаа бусадтай тайван, элэгсэг харьцах хэрэгтэй.

#### 3.1.3 Асуулгын хариуг бүрэн авах, лавлаж хянах талаар :

Асуултанд хариулж байгаа хүн нь хүндрэл, түвэгтэй зүйлийг санахыг хичээж байгаа үед нь

Та хариулахыг нь түр хүлээ. Хариулагчийг хэрхэвч яаруулж, тэвдүүлж болохгүй.

Шаардлагатай бол ярилцаж буй хүнээс хариултаа тодруулж өгөхийг хүс. Учир нь та түүнийг буруу, зөрүү ойлгож болох юм.

Хүүхдийн эхийн /асрагчийн/ өгсөн хариу нь хоорондоо хэр уялдаатай байгааг хяна. Тухайлбал өчигдөр хүүхдээ зөвхөн хөхөөрөө бүрэн хооллосон гэж хариулсан бол хүүхдэд нь энэ хугацаанд угжаар хооллосон, эсэхийг асуухад "Тийм" гэж хариулах ёсгүй. Ийм зөрчилтэй хариу өгсөн тохиолдолд асуултыг дахин асуух хэрэгтэй.

**Судалгааны асуулга, түүнийг хэрхэн асууж, нөхөх талаар****Судалгааны асуулгын Маягт. ХХС-1.****I. ӨРХИЙН АСУУЛГА****Хаягийн хэсэг:**

*Хаягийн хэсгийн асуулт бүрийн хариултын холбогдох кодыг харгалзах хүснэгтэнд бичнэ.*

**НН1-НН7. Өрхийн хаягийн хэсэг:**

**Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар, өрхийн дугаар, өрхийн байршил:** Судалгааны түүврийн нэгжийн дугаар болон өрхийн дугаар мөн ярилцлага авагч нарын хувийн дугаарыг ҮСГ-аас олгосон жагсаалтын дагуу нөхнө.

Судалгааг авсан он, сар, өдрийг бичнэ.

Өрхийн байршлыг засаг захиргааны байршлаас хамаарч нийслэл, аймгийн төв, сумын төв, хөдөөгөөр ялгаж, асуулганд өгөгдсөн кодийг тавина.

Тухайн өрхийн харьяалагдах засаг, захиргааны нэгжийн дагуу нийслэл, аймгийн нэрийг бич. Аймаг, нийслэл, сум, хорооны нэр, кодыг бичихдээ мөн ҮСГ-аас өгсөн жагсаалтыг ашиглана.

**НН8-** Өрхийн тэргүүлэгчийн нэрийг гаргацтай бичнэ. Өрхийн тэргүүлэгч гэж хэнийг хэлэхийг НЛ3-т тодорхой заасан байгаа.

**НН9-НН15В. Хяналтын хэсэг:**

Тухайн өрхөөс судалгааны асуултуудын хариултуудыг авч дууссаны дараа энэ хэсгийг нөхөж бичнэ. Судалгаанд хамрагдвал зохих хүн хэрхэн хамрагдсан байдлыг тодорхойлно. Өрхөөс судалгаанд хамрагдвал зохих 15-49 насны эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүдийн тоог “өрхийн ам бүлийн байдал” бүлгийн НЛ5 асуулгыг үндэслэн нөхөх ба мөн энэ насны судалгаанд хамрагдсан хүний тоог ХХС-2 асуулга ба ХХС-3 асуулгын хариултыг үндэслэн тодорхойлно.

**2. НЛ. ӨРХИЙН АМ БҮЛИЙН БАЙДАЛ**

*Өрхийн гишүүдийн нэр, нас, төрсөн он, нас, хүүхдүүдийн төрүүлсэн эцэг, эхийн талаархи мэдээллүүд хамаарна.*

Хүснэгтийн НЛ2 баганад өрхийн гишүүдийн нэрсийг өрхийн тэргүүлэгчээс эхлэн дараалуулан бичнэ. Нэрний харалдаа НЛ1 багана дахь дугаар нь өрхийн гишүүдийн хувийн дугаар болно. Энэ гишүүдийн хувийн дугаар нь тухайн өрхийн гишүүдийн хувьд дараагийн бүлгийн асуулганд ижил байх ба зарим асуултанд тухайн хүнийг төлөөлөн энэ дугаарыг

бичиж тэмдэглэнэ. Хэрвээ дараагийн бүлгүүдэд тухайн өрхийн гишүүн нь хариулах ёсгүй бол тэр гишүүний мөрийн дугаарын дагуу хоосон байх ёстой.

**Тодорхойлолт:** Өрхийн ам бүлийн тоонд гишүүдэд тухайн жилд 6 сараас дээш хугацаагаар гэртээ амьдраагүй, гэрээс алс суралцагчид, цэргийн алба хаагчдыг бүртгэхгүй. Харин тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар хамтран амьдарч, хооллож, хувцаслаж байгаа хүмүүсийг өрхийн гишүүнд бүртгэнэ.

**HL3- Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох:** Ярилцлага авагч нь өрхийн гишүүдийг өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг асууна. Энэ асуулт нь өрхийн гишүүдийг асуулганд бүрэн хамруулсан эсэх, дараагийн асуултуудыг бүрэн асуусан байдалд хяналт тавихад ихээхэн ач холбогдолтой. Өрхийн тэргүүлэгч гэж: өрхийн чухал асуудлуудыг шийдэхэд гол үүрэг гүйцэтгэдэг, өрхийн талаархи асуудлыг бүрэн хариуцдаг, ихэнхи тохиолдолд өрхийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэдэг мөн өрхийн бусад гишүүдийн талаар сайн мэддэг, өрхийн гишүүн байна. Хэн нь өрхийн тэргүүлэгч байхыг тухайн өрхийн гишүүд тодорхойлно. Өрхийн гишүүд нь өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг тогтоогоод зохих кодыг бич.

**HL4- Өрхийн гишүүдийн хүйс:** Өрхийн гишүүн нь эрэгтэй бол `1`; эмэгтэй бол `2` ын тоог дугуйл. Тухайн хүний хүйсийг түүний нэр, хувцас, төрх байдлаар ярилцлага авагч шууд тодорхойлж хэрхэвч болохгүй.

**HL4a- Төрсөн он.** Өрхийн гишүүдийн төрсөн оныг асууж дөрвөн оронтой тоогоор бичнэ. Тухайлбал 1987, 1920 он гэх мэт.

**HL5- Өрхийн гишүүдийн нас:** Өрхийн гишүүдийн насыг асууж HL5 баганад бич. Судалгаа авч байгаа өдрөөс урагш тоолож тухайн гишүүний бүтэн насыг тодорхойлно. *Жишээ нь: Судалгааг 2005.10.22-ны өдөр авч байвал 1945.10.25 -нд төрсөн хүний бүтэн насыг 59-өөр авна. Учир нь энэ хүний хувьд 60 нас хүрэхэд 3 хоног дутуу байна.* Өрхийн өндөр настнуудын насыг тогтооход бэрхшээлтэй байвал `мэдэхгүй` 98 гэсэн тоогоор тэмдэглэж болно. Харин 98 буюу түүнээс дээш настай хүний насыг 99 гэж нөхнө. Нярай хүүхэд нэг нас хүрээгүй бол, тухайлбал 9 сартай хүүхдийн насыг 00 гэсэн кодоор бүртгэнэ. Хүснэгтэд ямар ч хоосон зай үлдээхгүйгээр бүх хүүхдийн насыг нэг бүрчлэн заавал бүртгэж авсан байх ёстой.

**HL6-HL7-р асуулт нь судалгааны ХХС-1, ХХС-2 асуулганд хамрагдвал зохих гишүүдийг тодорхойлно.**

**HL6-** Өрхийн гишүүн 15 -49 насны эмэгтэйчүүдийн (үүнд 15 болон 49 настай эмэгтэйчүүд ч хамрагдана) хувийн дугааруудыг дугуйлж тэмдэглэнэ.

**HL7-** Өрхийн гишүүн, 5-17 насны хүүхэд (4 нас 11 сар 30 хоногтойгоос 17 нас 11 сар 29 хоногтой хүүхдүүд хамаарна) хамаарна. Өрхийн гишүүн 5-17 насны хүүхдүүдийг бүртгэсэн мөрнүүдийн харалдаа баганад тухайн хүүхдийн эх /асрагч/-ийн хувийн дугаарыг бичнэ.

**HL8-** Өрхийн гишүүн 5 хүртэлх насны хүүхдийг бүртгэсэн мөрний харалдаа (үүнд дөнгөж төрсөн хүүхдээс эхлэн 4 нас 11 сар 29 хоногтой хүүхдүүд хамаарна) түүний эхийн /асрагч/-ийн хувийн дугаарыг бичнэ.

**HL8A-** Сүүлийн 12 сард хүндээр өвчилсөн эсэхийг асууж нөхнө. Хүндээр өвчилсөн гэдэгт 3 сараас дээш хугацаагаар өвдсөнийг хамруулна.

**HL9-HL12A-** Хүүхдийн төрсөн эцэг, эхийн талаархи асуултууд.

*Эдгээр асуултаар 17 хүртэлх насны бүх хүүхдийн төрсөн эцэг, эх нь нэг гэр бүлд хамт амьдардаг эсэх болон хүнд өвчнөөр өвчилсөн эсэхийг тодорхойлно.*

*Төрсөн эх, эцэг гэдгийг төрүүлсэн гэсэн утгаар хэрэглэнэ.*

**HL9, HL11-** Тухайн хүүхдийн төрсөн эх/эцэг нь амьд сэрүүн байгаа бол 1, үгүй бол 2-ын тоог, харин хүүхдийн төрүүлсэн эх/эцэг нь амьд байгаа эсэхийг `Мэдэхгүй` гэж хариулбал 8-н тоог сонгоно. Та хүүхдийн төрүүлсэн эх/эцэг-ийн тухай асууж байгааг сайн ойлгуулсан байх ёстой.

**HL10, HL12.** Хүүхдийн төрсөн эх/эцэг нь нь хамт амьдардаг бол түүний хувийн дугаарыг бичнэ. Хэрэв төрсөн эх/эцэг нь тусдаа амьдардаг бол 00-ийн тоог бичнэ.

**HL10A, HL12A-** Төрүүлсэн эцэг/эх нь тусдаа амьдардаг бол сүүлийн 12 сард хүндээр өвчилсөн эсэхийг асууж, зохих хариултуудыг сонгоно.

### **3. ЕД. ӨРХИЙН ГИШҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ**

*Энэ бүлгийн асуултыг өрхийн 5 ба түүнээс дээш насны бүх гишүүдээс асууна.*

**ED1- Өрхийн гишүүдийн хувийн дугаар.**

Өрхийн гишүүдийн насыг лавлагаа хүснэгтээс харж 5 болон түүнээс дээш насны гишүүдийн хувийн дугаарыг дугуйлж тэмдэглэ. Уг гишүүдээс энэ бүлгийн асуултуудыг асууна.

**ED2-** Цэцэрлэг, сургуульд ер нь (амьдралынхаа туршид) хамрагдсан эсэхийг асууна. Тийм бол 1, Үгүй бол 2 гэсэн кодыг дугуйлж, дараагийн хүнээс асууна.

**ED3-** Өрхийн тухайн насны гишүүдийн суралцаж дүүргэсэн сургуулийн төрөл, анги (эзэмшсэн боловсролын түвшин)-ийг асууж холбогдох кодыг дугуйлна. Боловсролын хамгийн дээд түвшинээр тухайн хүний боловсролыг тодорхойлно. Жишээ нь Батаа нь 1981 онд ХАА-н техникум төгсөөд тусгай мэргэжлийн дунд боловсрол(коллеж) эзэмшсэн боловч 1998 онд ХААИС-ыг төгсөж бакалаврын дээд боловсрол эзэмшсэн байна. Тэгвэл их сургууль -3 гэж бичнэ.

*Анги:* Сургуульд сурч байсан гэхдээ нэг ч анги төгсөөгүй тохиолдолд ангийн дугаарыг 00, хэрэв төгссөн эсэх мөн төгссөн ангийн дугаарыг мэдэхгүй бол 98 гэж бич. Их, дээд, тусгай мэргэжлийн дунд сургууль, коллежийн хувьд: ангийн дугаар гэдэгт курсын дугаарыг бичнэ.

**5-24 насны хүмүүсээс дараах асуултуудыг асууж нөхнө.**

**ED4- 2005-2006 оны хичээлийн жилд (Одоо) цэцэрлэг, сургуульд хамрагдсан уу?**

Судалгаа явж байгаа үед ямар нэгэн цэцэрлэг, сургуульд сурч байгаа бол 1 гэж бичээд дараагийн асуултуудыг асууна.

**ED5-** Судалгаа авч байгаа өдрийн урдах 7 хоногт хэдэн хоног сургууль, цэцэрлэгт хамрагдаад байгааг асууж, нөхнө.

**ED6-** Суралцаж байгаа сургуулийн код болон ангийн дугаарыг бичнэ. Асуултын хариултанд дараахь кодийг хэрэглэ.

Сургууль:

Сургуулийн өмнөх насны боловсролын байгууллага (цэцэрлэг) -0

ЕБС -1

МСҮТ -2

Их, дээд, сургууль, коллеж -3

Албан бус сургалт 4

Шашны сургууль -5

Мэдэхгүй -8

**ED 7-ED8. Өмнөх хичээлийн жилд 2004-2005 оны хичээлийн жилд цэцэрлэг, сургуульд хамрагдсан уу?**

Ямар нэгэн цэцэрлэг, сургуульд сурч байсан 1 гэж бичээд дараагийн асуултуудыг асууна.

Суралцаж байсан ангийн дугаарыг `анги` гэсэн баганад бичнэ. Асуултын хариултанд дараахь кодийг хэрэглэ.

Сургууль:

Сургуулийн өмнөх насны боловсролын байгууллага (цэцэрлэг) -0

ЕБС -1

МСҮТ -2

Их, дээд, сургууль, коллеж -3

Албан бус сургалт 4

Шашны сургууль -5

Мэдэхгүй -8

**4. WS. УНДНЫ УСНЫ БОЛОН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХАНГАМЖ****WS1. Танайх ундны усаа голдуу ямар эх үүсвэрээс авдаг вэ ?**

Өрхийн гишүүдийн ундны усны хангамж нь найдвартай эсэхийг тодорхойлоход энэ асуултын зорилго оршино. Ундны усаа хангамжийн хэд хэдэн эх үүсвэрээс авдаг бол гол төлөв ямар эх үүсвэрээс авдгийг нь сонгон авч түүний харгалзах кодийг дугуйл. Хэрэв ундны усны эх үүсвэр нь улирлаас шалтгаалан янз бүр байдаг бол ярилцлага хийж байгаа тухайн улиралд ямар эх үүсвэрээс ус авч байгааг сонгож, холбогдох кодыг дугуйл.

**WS3. Ундны усаа ус түгээх цэгээс авахад хэдэн цаг зарцуулдаг вэ ?**



Энэ асуултаар ундны усаа бэлтгэхэд ямар хугацаа зарцуулдагийг тодорхойлох зорилготой. Тээврийн ердийн хэрэгслээр болон явганаар усны цэгт очиж, ээлж дараалал хүлээгээд ус аваад гэртээ ирэхэд хэдэн цаг зарцуулдагийг тэмдэглэж авна (энэ хугацааг минутаар хэмжиж, шаардлагатай бол цагийг минутанд шилжүүлнэ. `Мэдэхгүй` гэж хариулбал 998 гэсэн тоог дугуйл.

**WS4-** Усандаа ихэвчлэн явдаг том хүн болон хүүхдийг хүйсээр ялгаж зохих коыг тэмдэглэнэ. Хариултын нэг код л байх ёстой сонгоно.

**WS5-WS6** Ундны усаа найдвартай байлгах арга хэрэглэдэг эсэхийг асууж, тийм бол WS6 асуултны хариултын кодуудаас нэрлэсэн бүгдийг сонгоно.

**WS7- Танайх ямар төрлийн жорлон хэрэглэдэг вэ?**

Энэ асуултаар өрхийн гишүүдийн хэрэглэж жорлонгийн нөхцөл байдалд үнэлгээ өгнө. Бохирын сувагт буюу бохир усны нэгдсэн системд холбогдсон бол 11 байна.

Нүхэн жорлон гэдэг нь зориудын болон тусгайлсан пинтэй (гэр хороололд ихэвчлэн байдаг) жорлон бөгөөд харин сайжруулсан нүхэн жорлон нь агааржуулагч хоолой буюу яндантай, байна. Ухсан нүх гэдэг нь нь (ихэвчлэн хөдөөд байдаг) нүхийг таар, шуудайгаар халхалсан жорлон юм.

## **5. HC1. ӨРХИЙН ЗАРИМ ТОДОРХОЙЛОЛТ**

**HC1.A-HC1.C** Өрхийн тэргүүлэгчийн шүтдэг шашин, эх хэл, яс үндсийг асууж, холбогдох кодыг бичнэ.

**HC1.D-8.A Сууцны төрөл** . Сууц гэдэгт байшин, гэр хоёул хамрагдана. Хэрэв тухайн өрх байшин, гэр хоёулантэй бөгөөд бүгдийг хэрэглэж байгаа бол жилийн туршид тэдгээрийн аль удаан хугацаагаар ашигладгийг (үндсэн сууц) нь сонгон авна.

Өрхийн амьдарч байгаа сууц нь асуулганд өгөгдсөн төрлийн алинд нь хамаарахыг тодорхойл. Үүнд: Нийтийн сууцны байшин дотор өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, тоноглол, төхөөрөмжтэй бусад айлаас тусгаарлагдсан зориулалтын ханатай, нэгдсэн шат, хонгил, эсвэл гудамж руу шууд гарах хаалгатай нэг айл суухад зориулагдсан сууцыг **нийтийн сууцны байшин доторхи сууц-1** гэнэ. Орон сууцны зориулалтын зураг төслөөр баригдсан, зориулалтын зураг төсөлгүй боловч иргэд өөрсдөө сууцанд зориулж барьсан нэг буюу хэд хэдэн өрх суухад зориулан төхөөрөмжлөгдсөн, дэд бүтцийн холбогдох хангамжтай бол **сууцны тусдаа байшин-2**-т хамааруулна. Оюутан, сурагчдын дотуур байр, ажилчдын нийтийн байр болон нийтийн эзэмшлийн бусад байр 3-т хамаарна. Үндэсний гэр сууц болон цаатангуудын суудаг урцыг **Гэр-4**, сууцны дээрхи төрөлд хамрагдаагүй сууцыг /вагончиг, зориулалтын бус байшин зэрэг/ **Бусад-5**-д хамруулж тодруулан бичнэ.

**HC1.F- Сууцны талбай, кв.м** `Сууцны талбай` нь тухайн сууцны зочин, унтлага, амралт болон ажлын өрөөний талбайн нийлбэрээр тодорхойлогдоно. Сууцны талбайд тусдаа гал тогоо, жорлон, угаалгын өрөө, коридорын талбай хамаарахгүй.

**НС1.Г- Өрөөний тоо.** Өрөөний тоонд гал зуух, жорлон, коридор зэргийг оруулахгүй.

**НС1.Л- Гэрийн ханын тоо.** Гэрийн ханын тоог асууж бичнэ.

**НС3- Сууцны шалны үндсэн материал.** Өрхийн эзэмшиж байгаа сууцны шалны үндсэн материалыг үндэслэж, хариултын кодийг ашиглан нөхнө.

**НС4-Дээврийн материал.** Байшингийн дээвэр талыг бүрсэн материалыг асууна.

**НС5- Байшингийн ханын үндсэн материал.** Өрхийн эзэмшиж байгаа сууцны ханын үндсэн материалыг үндэслэж, кодийг ашиглан хариултыг нөхнө.

**НС1.Е- Сууцны эзэмшил.** Өрхийн эзэмшиж байгаа сууц нь хэний өмч болохыг тодорхойлж, дараахи кодийг ашиглан хариултыг нөхнө.

**НС11-12. Танайх хувийн тариалангийн талбайтай юу?** Талбайтай бол хэмжээг га-гаар бич.

**НС13-14. Танайх хувийн малтай юу? ямар төрлийн хичнээн малтай вэ?** Өрхийн малын тоог асууж төрлөөр нь ялгаж бич.

#### **OV. ӨНЧИН ХҮҮХДИЙН ТАЛААРХ АСУУЛГА**

Энэхүү асуулга хоёр хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэг нь сүүлийн 12 сард нас барсан, 3 сараар хүндээр өвчилсөн 18-59 насны ядаж нэг хүн өрхөд байгаа эсэхийг тодорхойлно. Энэ нь уг асуулгад тохирох 0-17 насны хүүхэд байгааг тодорхойлох эхний шалгуур, дээр нь Өрхийн ам бүлийн байдлын бүлэг дэх нэмэлт шалгуур болно. Хоёр дахь хэсэг нь тухайн өрхийн 0-17 насны хүүхдүүдэд үзүүлсэн тусламжийн төрлийн талаар асууна.

##### **OV1. Н15-г шалга: 0-17 насны хүүхэд байна уу?**

N15 баганыг шалган, өрхөд 0-17 насны (17 настай бол оруулна) хүүхэд байгаа эсэхийг харна. Хэрэв “Тийм” бол дөрвөлжин нүдийг бөглөн дараагийн асуултыг үргэлжлүүлэн асууна. Хэрэв “Үгүй” бол дараагийн дөрвөлжин нүдийг бөглөн дараагийн асуулга руу очно.

**OV2. Та сүүлийн 12 сарыг эргэж бодно уу? Сүүлийн 12 сард танай гэр бүлийнхнээс хэн нэг нь нас барсан уу? Энэ асуултыг асуухдаа ихээхэн болгоомжтой хандах нь чухал.**

Сүүлийн 12 сарын хугацаанд хэн нэг нь нас барсан эсэхийг тодруулна. Хэрэв тэд хэдэн сард хүн нас барсан эсэхийг санахгүй байвал хариулагчид туслах зорилгоор тандаж асуух хэрэгтэй. Хариултын кодыг дугуйлна. Хэрэв “Тийм” гэж хариулсан бол дараагийн асуултыг асууна. Хэрэв “Үгүй” гэж хариулсан бол OV5 хүртэл алгасна.

##### **OV3. Талийгаач 18-59 насны хүн байсан уу?**

Хариултын кодыг дугуйлна. Хэрэв “Тийм” гэж хариулсан бол дараагийн асуултыг асууна. Хэрэв “Үгүй” гэж хариулсан бол OV5 хүртэл алгасна.

##### **OV4. Талийгаач сүүлийн 12 сарын 3-аас дээш сараар хүндээр өвчилж байсан уу?**

Хариултын кодыг дугуйлна.

Хэрэв талийгаач ажил эсвэл гэртээ хоол хийх, цэвэрлэгээ хийх, машин жолоодох, ажил хэрэгт оролцох гэх зэрэг хэвийн үйл ажиллагаагаа гүйцэтгэж чадахгүй байсан бол “хүнд өвчин” гэж ойлгуулах хэрэгтэй. Мөн бид онцгойлон гурван сараар эсвэл өмнөх 12 сарын хугацаанд түүнээс дээш хугацаагаар өвчтэй байсан эсэхийг асууж байгаа гэдгийг санах хэрэгтэй. Өвчнүүд нь дараалсан байх шаардлагагүй.

Хэрэв “Тийм” гэж хариулсан бол OV8 хүртэл алгасч хүүхдүүдэд үзүүлсэн тусламж дэмжлэгийн тогтолцооны талаар асууна. Энэ асуултын “Тийм” гэсэн хариулт нь өнгөрсөн 12 сарын хугацаанд нас барсан 18-59 насны хүн нь 3 сарын хугацаанд хүнд өвчин туссан нэг хүн байна гэсэн утгатай юм. Хэрэв “Үгүй” асуулт OV5-ын шалгалтыг үргэлжлүүлэн хийнэ.

**OV5. Өрхийн асуулга руу эргэж очин дараахь асуулгуудыг шалгана уу?**

1. Нас барсан эхийн тоо 0-ээс их эсвэл нас барсан эцэгийн тоо 0-ээс их эсэх (HL9, HL11-ээс).
2. Өнгөрсөн 12 сарын хугацаанд 3-аас дээш сараар хүндээр өвчилсөн 18-59 насны насанд хүрэгчдийн тоо 0-ээс их эсэх.
3. Өнгөрсөн 12 сарын хугацаанд 3-аас дээш сараар хүндээр өвчилсөн өрхөд амьдардаггүй эцэг эсвэл эхийн тоо 0-ээс их эсэх.

Хэрэв эдгээр нийлбэрүүдийн аль нэг нь 0-ээс их байвал энэ нь өрхөд өнчин болон эмзэг хүүхэд байгаа гэсэн утгатай бөгөөд OV8-OV18 асуултуудыг асуух ёстой.

**7. ОР. ДЭМЖЛЭГ, ТУСЛАМЖ**

**OV8. 0-17 хүртэлх насны хүүхдүүдийн дугаарыг лавлагаа хүснэгтээс харж дугуйлна. Асуулгыг нэг хүүхдээс нь асууж дууссаны дараа дараагийн хүүхдээс асуу.**

Хэрэв OV4 асуултад “Тийм” гэж хариулсан эсвэл OV5-д “0”-ээс их утга гарсан бол өрхийн бүх хүүхдүүд эмзэг байна гэж үзнэ. Иймэс бүх хүүхдүүд энэ асуулгад оролцоно. OV10-OV18 асуултыг нэг хүүхдийн тухай асууж дууссаны дараа дараагийн хүүхдээс асуух ёстой.

**OV9. Би та бүхнээс танай гэр бүлийнхний засгийн газар, хувийн сектор, шашны болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд хамрагдаж хүлээж авсан тусламж дэмжлэгийн талаар асууж ярилцъя.**

Хүүхэд бүрээс OV10-OV18 асуултуудыг асууж эхлэхээс өмнө хариулагчид OV9-д юуг оруулж байгааг уншиж өгөх хэрэгтэй. Энэхүү асуулгад хариулагч нь Өрхийн асуулгад

хариулагч байж болох бөгөөд OV8-д бичигдсэн хүүхдүүдийн эх/асрагч байх шаардлагагүй гэдгийг сануулж хэлэх хэрэгтэй.

Бид тухайн өрхийн хүүхэддээ хүлээн авсан **бүх** тусламж дэмжлэгийн талаар асуухгүй, ямар нэг байгууллагаас үзүүлсэн зохион байгуулалттай, албан ёсны тусламж дэмжлэгийн талаар цохон асуух болно. Судалгаа дараахь төрлийн тусламж дэмжлэгийн талаар олж мэдэх зорилготой.

- албан ёсны, зохион байгуулалттай тусламж дэмжлэг (засгийн газар, хувийн сектор, шашны, хүмүүнлэгийн, олон нийтийн байгууллагын)
- үнэ төлбөргүй үзүүлсэн, өрх ямар нэг төлбөр төлөөгүй
- тусламжийг тухайн хүүхдэд онцгойлон үзүүлсэн.

Тухайн төрлийн тусламж орох, орохгүй эсэх талаар жишээ авч үзье. Ээж нь хоолоо хийж чадахгүй өвчтэй байх үед хөрш нь гэр бүлийнхэнд хоол хийж өгөх. Энэхүү тусламж нь өрхөд чухал ач холбогдолтой, гэхдээ хөрш нь сайхан сэтгэлээрээ туслаж байгаа бол энд оруулахгүй. Харин ямар нэгэн байгууллагаас өгсөн үүргийн дагуу хоолоо хийж чадахгүй өвчтэй хүмүүст хоол хийж өгч үйлчилж (үнэгүй) байгаа бол энэ төрлийн туслалцаа энд оруулна.

***OV10. Сүүлийн 12 сард (нэр) эрүүл мэндийн холбогдолтой ямар нэг тусламж авсан уу? (эрүүл мэндийн тусламж, эмийн хангамж)***

Өгсөн хариултын кодыг дугуйлна.

***OV11. Сүүлийн 12 сард (нэр) сэтгэл санааны тусламж болох аливаа халамжийн төвийн дэмжлэг туслалцаа эсвэл оюун санааны дэмжлэг авсан уу?***

Өгсөн хариултын кодыг дугуйлна. Хэрэв өрх энэ төрлийн тусламж дэмжлэг хүүхэддээ аваагүй бол OV13 хүртэл алгасна.

***OV12. (Нэр) сүүлийн 3 сард дээрх төрлийн туслалцаа дэмжлэг авсан уу?***

Эрүүл мэндийн тусламжийг сүүлийн 3 сард үнэ төлбөргүйгээр үзүүлсэн бол “Тийм” гэж хариулна. Энэхүү төрлийн тусламж нь бусад төрлийн тусламжаас илүү нийтлэг шаардагддаг учраас энэхүү асуултад 12 сар дээр нэмээд 3 сар болгож асууж байгаа юм. Өгсөн хариултын кодыг дугуйлна.

***OV13. Сүүлийн 12 сард (нэр) хувцас, хоол хүнс, мөнгө төгрөг гэх мэт материаллаг тусламж авсан уу?***

Өгсөн хариултын кодыг дугуйлна. Хэрэв өрх энэ төрлийн тусламж дэмжлэг хүүхэддээ аваагүй бол OV15 хүртэл алгасна.

**OV14. (Нэр) сүүлийн 3 сард дээрх төрлийн туслалцаа дэмжлэг авсан уу?**

Материаллаг тусламжийг сүүлийн 3 сард үнэ төлбөргүйгээр үзүүлсэн бол “Тийм” гэж хариулна. Энэхүү төрлийн тусламж нь бусад төрлийн тусламжаас илүү нийтлэг шаардагддаг учраас энэхүү асуултад 12 сар дээр нэмээд 3 сар болгож асууж байгаа юм. Өгсөн хариултын кодыг дугуйлна.

**OV15. Сүүлийн 12 сард (нэр) гэр орны ажилд туслах, сургалтанд хамруулах, хуулийн үйлчилгээ үзүүлэх г.м нийгмийн тусламж дэмжлэг хүртсэн ҮҮ?**

Өгсөн хариултын кодыг дугуйлна. Хэрэв өрх энэ төрлийн тусламж дэмжлэг хүүхэддээ аваагүй бол OV17 хүртэл алгасна.

**OV16. (Нэр) сүүлийн 3 сард дээрх төрлийн тусламж, дэмжлэг авсан уу?**

Нийгмийн тусламж дэмжлэгийг сүүлийн 3 сард үнэ төлбөргүйгээр үзүүлсэн бол “Тийм” гэж хариулна. Энэхүү төрлийн тусламж нь бусад төрлийн тусламжаас илүү нийтлэг байдаг учраас энэхүү асуултад 12 сар дээр нэмээд 3 сар болгож асууж байгаа юм. Өгсөн хариултын кодыг дугуйлна.

**OV17. OV-аас хүүхдийн насыг шалга:**

Үлдсэн асуулт (OV18) нь зөвхөн 5-17 насны хүүхдүүдэд хамаарах юм. Хэрэв хүүхэд 5-аас доош настай бол эхний нүдэнд тэмдэглээд дараагийн хүүхэд рүү очно. Нэрсийн жагсаалтад өөр хүүхэд байхгүй бол дараагийн асуулга руу очно.

**OV18. Сүүлийн 12 сард танай гэр бүл сургуульд үнэгүй суралцах, сургалтын төлбөр, ном авах зэрэг тусламж авч байсан уу?**

Хүүхэддээ ном, хичээлийн хэрэгсэл, эсвэл мөнгөн нөхөн олговор зэрэг сургуультай холбоотой ямар нэг тусламж авч байсан эсэхийг асууна. Өгсөн хариултын кодыг дугуйлна.

**8. CL. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

Энэ бүлгийн асуулгыг 5-17 настай хүүхдийн (үүнд 5 болон 17 настай хүүхэд хамаарна) эхээс /асрагч/ асууна. Энэ асуулгаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судлана.

**CL1-Хүүхдийн хувийн дугаар.** Энэ бүлгийн асуулганд хамрагдвал зохих 5-17 насны хүүхдүүдийг лавлагаа хүснэгтийг үндэслэн тодорхойлж хувийн дугаарыг дугуйлна.

**CL3- Сүүлийн долоо хоногт ... (нэр) өрхөөс гадуур ямар нэг ажил хийсэн үү ?**

Хүүхэд ажил хийсэн/хөдөлмөр эрхэлсэн гэж хариулсан тохиолдолд түүнээс төлбөртэй

хөдөлмөр эрхэлсэн эсэхийг лавлан асууж, хөлстэй хөдөлмөр эрхэлсэн бол 1-ийн тоог, хөлс аваагүй бол 2-ын тоог дугуйл. Хөлс гэдэг нь ажлын хөлс, цалин, шагнал, тухайлбал тэр хүүхдэд болон түүний гэр бүлд нь бэлэн мөнгө, бараа өгсөн эсвэл ямар нэг үйлчилгээ үзүүлснийг хэлнэ.

**CL4- Сүүлийн долоо хоногт хэдэн цаг ажилласан бэ ?**

Сүүлийн долоо хоногт өрхийн гишүүн бус хэн нэгэнд болон байгууллагад хүүхдийн ажилласан цагийн нийлбэр дүнг бичээд 6 дугаар асуулт руу оч. Ингэхдээ асуугаагүй орхисон асуултуудыг зураасаар дарна. `Сүүлийн 7 хоногт [долоо хоногийн өдөр]` гэдэг үгийн утгыг асран хүмүүжүүлэгч хүн нь зөв ойлгосон гэдгийг баттай мэдэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Боловсролын бүлэгт тодорхойлсонтой адил өнөөдөр бол долоо хоногийн хэддэх өдөр вэ гэдгийг тодорхой хэлж, сүүлийн 7 хоногийг тодорхойл. Хэрэв тэр хүүхэд хэд хэдэн төрлийн ажил хийсэн байвал энэ бүх төрлийн ажил хийхэд нийтдээ хэдэн цаг зарцуулсаныг бүртгэнэ.

**CL5- Сүүлийн жилд өрхөөсөө гадуур ямар нэг ажил хийсэн үү ?** Хэрэв `тийм, ажилласан` гэвэл хийсэн ажлын хөлс авсаныг лавлаад хөлс авсан бол 1-ийн тоог, хөлс аваагүй бол 2-ын тоог дугуйл.

**CL6-7. Сүүлийн долоо хоногт ...[нэр] нь гэрийнхээ ажилд тусалсан уу? (тухайлбал: хоол хийх, дэлгүүр явах, цэвэрлэгээ хийх, хувцас угаах, ус зөөх, хүүхэд харах гэх мэт) Хэдэн цаг зарцуулсан бэ?**

Хүүхэд гэрийнхээ ажилд туслаж хоол бэлтгэсэн, дэлгүүр явсан, дүүгээ асарсан, гэрээ цэвэрлэсэн, ус зөөсөн, г.м ажил хийсэн гэж хариулбал 1-ийн тоог дугуйлаад 7 дугаар асуултыг асуу. Энэ бүх ажлыг долоо хоногийн туршид хийхэд хэдэн цаг зарцуулсныг асууж ажилласан цагийн нийлбэр дүнг 7-р асуултанд бичнэ. Хэрэв `үгүй` бол 2-ын тоог дугуйлаад 8 дугаар асуултыг асуух ба асуугаагүй орхисон асуултуудыг зураасаар дарна.

**CL 8-10. Сүүлийн долоо хоногт .... [нэр] нь өрх, гэрийнхээ үйлдвэрлэл, бизнесийн бусад ажил (тухайлбал мал маллах, захиалгат болон худалдах зүйл оёх, г.м өрхийн үйлдвэрлэл бизнесийн ажил) хийж байсан уу ? Хэдэн цаг ажилласан бэ?**

Хэрэв өрхийнхөө орлого олох зориулалттай тийм ажилд тусалцаж байсан бол 1-ийн тоог дугуйлаад 9 дүгээр асуултыг асуу. Хэрэв `үгүй` бол 2-ын тоог дугуйлаад дараачийн дугаарт бүртгэгдсэн хүүхдээс энэ бүлгийн асуултыг эхнээс нь асуу. `Өрхийн бусад ажил` гэдэг нь гэр ахуйн ажлаас гадна бусад ажилд тухайлбал өрхийн орлого бүрдүүлэх, үйлдвэрлэл явуулахад туслах, өрхийн мал маллах эсвэл гэр бүлийн бизнесийн үйлдвэрт ажиллахыг хамааруулна. Ажилласан цагийн тоог бич.Өрхийн бизнесийн үйлдвэрлэл аль салбарт хамаарахыг асууж тодорхойлон холбогдох кодийг бичнэ.

**9. CD. ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖИЛ, ТӨЛӨВШИЛ, ХЭВ ЗУРШИЛ**

Тухайн өрхийн 2-14 насны нэг хүүхдийн хүмүүжлийн талаар асууж ярилцана. Хэрвээ тухайн өрх 2-14 насны нэг хүүхэдтэй бол Хүснэгт1-ийг нөхөж, CD11 асуултаас эхэлж асууна. Олон

хүүхэд байгаа бол Хүснэгт 2-ийг ашиглан зааврын дагуу аль нэг хүүхдийг сонгож, сонгогдсон хүүхдийн тухай CD11 асуултаас эхлэн асууна.

**CD2- CD 5** Хүүхдийн (2-14 насны) мөрийн дугаар, нэр, хүйс, насыг бичнэ.

**CD6-** Эх асрагчийн мөрийн дугаарыг бичихдээ “Өрхийн ам бүлийн байдал” бүлгийн HL7, HL8 гэсэн асуултуудаас (баганаас) харж бичнэ.

**CD7-** Тухайн өрхийн 2-14 насны хүүхдийн тоог бичнэ.

**CD8-CD9** Тухайн өрхөд уг насны 2 болон түүнээс дээш хүүхэд байвал Хүснэгт2 дах зааварыг ашиглан “Хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хэв зуршил” бүлгийн асуулгад хамрагдах нэг хүүхдийг сонгоно.

**CD11-** Сонгогдсон хүүхдийн нэр болон мөрийн дугаарыг бичнэ.

**CD12B. Гаргасан зан ааш нь буруу болохыг тайлбарласан уу?**

Хүүхэд ямар нэг буруу зүйл хийсэн үед зарим эцэг эх/асрагчид гаргасан зан аашийг нь яагаад буруу гэж үзэж байгаагаа тайлбарлаж өгөх замаар энэхүү зан аашаа дахин давтаж болохгүйг сургахыг хичээдэг. Жишээлбэл, жаахан хүүхэд шүдэнзээр тоглож болохгүй, учир нь хүүхэд санамсаргүйгээр гал алдах болно гэдгийг хэлсэн байж болох юм.

**CD12D. Түүнийг загнасан уу?**

Эцэг эх/асрагч нь хүүхдээ ямар нэг буруу зүйл хийсэн гэж үзсэн загнах, дуу хоолойгоо өндөрсгөсөн байж болно.

**CD12E. Түүнийг шийтгэж, ямар нэг ажил хийлгэхээр өгсөн үү?**

Энэ төрөл нь буруу зан аашнаас нь хүүхдийн анхаарлыг сарниулах хүчирхийллийн бус хүмүүжлийн аргуудын нэг юм. Эцэг эх/асрагч гаргасан зохимжгүй зан аашнаас нь хүүхдийн анхаарлыг сарниулах зорилгоор тухайн байрлалд хүүхдэд ямар нэг өөр зүйл хийлгэхээр өгсөн байж болно. Хэрэв хариулагч ойлгоогүй тохиолдолд “Энэ нь хүүхдийн анхаарлыг сарниулах эсвэл хүүхдийн анхаарлыг ямар нэг өөр зүйлд хандуулах гэсэн утгатай юм” гэж тандан хэлж болно.

**CD12H. Түүнийг тэнэг, залхуугаар нь дуудсан уу?**

Зарим эцэг эх/асрагч нар хүүхдийг буруу зан ааш гаргахгүй байхыг сургах зорилгоор аман доромжлолыг хэрэглэдэг.

**CD12K. Түүнийг зодсон уу?**

Энэ бол уг асуулгад асуусан бие махбодийн шийтгэлийн хамгийн хатуу хэлбэр нь юм. Энэ асуулт нь саваа, бүс, таяг гэх зэрэг зөөлөн эсвэл хатуу зүйл ашиглах, эсвэл өөр бусад зүйлээр хүүхдийг дахин давтан зодох шийтгэлийг илэрхийлж байна

**CD13.** Түүнд бие махбодийн шийтгэл оногдуулах түүний хүмүүжилд сайнаар нөлөөлнө гэдэгт Та итгэж байна уу?

Энэ асуулт нь эцэг эх/асрагчийн хүүхдийн хүмүүжилд хандах хандлагыг илрүүлэхэд чиглэгдсэн бөгөөд уг асуултыг эцэг эх/асрагчийн хүүхдээ хүмүүжүүлэх төлөв байдлын талаар асуусны дараа хамгийн сүүлд асуух ёстой. Эцэг эх/асрагчаас хүүхдэд зөвөөр биеэ авч явахыг сургахдаа бие махбодийн шийтгэл хэрэглэх шаардлагатай эсэх талаар тэдний санаа бодлыг тодруулах асуулт юм. Хэрэв эцэг эх/асрагч нь өмнөх асуултуудад бие махбодийн шийтгэлийн өөр хэлбэрийг ашигласан гэж хариулсан атал энэ асуултанд энэ шийтгэлийг хэрэглэх шаардлагагүй гэж хариулсан тохиолдолд гайхах хэрэггүй.

**CD14- CD21** Асуултууд нь хүүхдийн хөгжил, төлөвшилд эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн оролцоо, хандлага ямар байгааг тандах зорилготой.

**CD22- CD23** Хүүхдийн гэмтлийн тухай асуултууд нь хүүхдэд тавих хараа хяналт хэр өндөр байгааг илрүүлэх зорилготой. Хүүхэд хаана гэмтэл авснаас үл хамааран юунаас болж гэмтэл авсныг сүүлийн сарын байдлаар тодорхойлно.

**CD24-** Тогтмол хооллолт нь тогтсон цагт нь (өдрийн 3-4 удаагийн цадахуйц хэмжээгээр) хооллохыг хэлнэ.

**CD25-** Тогтмол цагт унтана гэдэг нь хүүхэд орой унтдаг тэр л цагтаа /+,- 30 минут/ унтдаг эсэхийг тодруулах зорилготой.

**CD26-CD28, CD30-** Шүд болон гараа угааж хэвшсэн эсэхийг асууна.

**CD29-** 7 хоногт 1 ба түүнээс дээш удаа усанд ордог/оруулдаг бол байнга, сараас дээш хугацаанд 1 удаа ордог бол үгүй гэсэн хариултыг сонгоно. Бусад тохиолдолд хааяа гэсэн хариултыг бөглөнө.

**CD31-** Цаг агаарт тохируулан хувцаслана гэдэг нь хүйтэнд хөнгөн нимгэн, халуунд зузаан хувцасладаггүй, нартайд малгай өмсч, бороотойд цувтай явах гэх мэт цаг агаарт тохируулан хувцаслахыг хэлнэ.

## **10. DA. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД**

Энэ бүлгийн асуулгыг тухайн өрхөд амьдарч байгаа 18 хүртэл насны хүүхдүүдийн эх болон асрагч нараас асууна.

**DA1- Хувийн дугаар** Энэ бүлгийн асуулганд хамрагдвал зохих 2-9 насны хүүхдүүдийг лавлагаа хүснэгтийг үндэслэн тодорхойлж хувийн дугаарыг дугуйлна.

**DA3- Бусад хүүхдүүдтэй харьцуулахад явах, суух, зогсохдоо хүндрэлтэй байдаг уу?** Өрхийн 2-9 насны хүүхэд бие эрхтний төрөлхийн болон олдмол согогтой эсэх нь илт



мэдэгдэхээр бол шууд тэмдэглэх, мэдэгдэхгүй тохиолдолд маш эвтэйхэн асууна. Тийм гэсэн тохиолдолд 1, үгүй бол 2-ийн тоог дугуйл.

**DA4- Өдөр болон шөнийн цагаар юм харахад хүндрэлтэй байдаг уу?** Өрхийн бага насны хүүхэд харааны хүндрэлтэй эсэх нь илт мэдэгдэхээр бол шууд тэмдэглэх, мэдэгдэхгүй тохиолдолд маш эвтэйхэн байдлаар асууж тодруул. Хол, ойрын харах чадвар муу, нүдний өвчтэй г,м байж болно.

**DA5- Сонсох эрхтний бэрхшээлтэй юу?** Өрхийн бага насны хүүхэд сонсголын эрхтний төрөлхийн болон олдмол согогтой эсэх нь илт мэдэгдэхээр бол шууд тэмдэглэх, мэдэгдэхгүй тохиолдолд маш эвтэйхэн байдлаар асуу. Сонсголын аппарат хэрэглэдэг эсэх, сонсгол муутай, огт сонсдоггүй байж болно. Холбогдох тоог дугуйл.

**DA6- Таны хэлсэнийг хир ойлгож гүйцэтгэж, чаддаг уу?** Тухайн хүүхэд ямар нэг зүйлийг хий гэсний дагуу хийдэг эсэх, хэлснийг бүрэн ойлгодог бол Тийм 1, үгүй бол 2-ийн тоог дугуйл.

**DA7- Явахад болон гараа хөдөлгөхөд хүндрэл байдаг э сэх, хөл гар нь ямар нэгэн зовиуртай эсэх?**

**DA8- Заримдаа татаж унаж, ухаан алддаг уу?**

Унадаг, ухаан алддаг бол Тийм-1, Үгүй бол 2-ийн тоог дугуйл.

**DA9- Үеийн хүүхдүүдтэйгээ адилаар ямар нэг зүйлийг хийж чаддаг уу?**

**DA10- Түүний хэлж байгаа үг ойлгогдохуйц байж чаддаг уу?** Өөрийгөө ойлгуулж чаддаг эсэхийг тодруулна.

**DA11- 3-9 настай хүүхдүүдын хувьд хэл яриа нь хэвийн эсэх, ойр дотныхоос бусад хүмүүс ойлгодог эсэхийг асууж нөхнө.**

**DA12- 2 настай хүүхдүүдээс ямар нэгэн зүйлийг нэрлэж чаддаг эсэхийг асууна.**

**DA13- Оюун ухааны хоцрогдол (хомсдол) бий эсэхийг асууна.**

## 11. ММ. ЭХИЙН ЭНДЭГДЭЛ

*Эхийн эндэгдэлд жирэмсэн эмэгтэйчүүдийн нас баралт, хүүхэд төрүүлэх үеийн нас баралт, төрсөний дараахи үеийн нас баралтыг хамруулна. Төрсөний дараахи үеийн нас баралтанд төрсөний дараахи 6 долоо хоногт нас барсан эхчүүдийг хамруулна.*

*Энэ бүлгийн асуулганд судалгаанд хамрагдсан өрхийн 15 болон түүнээс дээш насны (гэрлэсэн болон гэрлэж байсан) бүх гишүүд хамаарна.*

Энэ бүлгийн асуулгаар судалгаанд хамрагдаж байгаа өрхийн гишүүдээс түүний нэг эхээс төрсөн эгч, эмэгтэй дүүсийн талаар асуух болно. Иймээс эгч дүүс гэдэгт **эх нэгтэй** эгч, эмэгтэй дүүсийг хамруулж ойлгохыг анхаар. Энэ бүлгийн 4-9 асуултыг 2 оронтой тоогоор нөхнө.

**ММ3- ММ4** Асуултад өөрөө хариулж буй эсэхийг тодорхойлно.

Харин бусдын өмнөөс асуултанд хариулсан хүний хувийн дугаарыг асуулгын 4-р баганад бичнэ.

**ММ4А- Төрсөн эгч, эмэгтэй дүүтэй эсэх?** –ийг тодорхойлж тийм бол дараагийн асуултуудыг асууна, үгүй бол дараагийн бүлэг рүү очно.

**ММ5- Та нэг эхээс төрсөн хэдэн эгч, (эмэгтэй)дүүтэй вэ?**

Энэ асуултаар судалгаанд хамрагдагч нь хэдэн эгч, эмэгтэй дүүтэй байгаа болон байсныг асууж тодорхойлно. Тэгэхээр судалгаанд хамрагдагчтай нэг эхээс төрсөн түүний эгч, эмэгтэй дүүгийн талаар (тэдний хаана амьдардаг болон одоо байгаа, нас барсан эсэхээс үл хамаарч) асууж байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй. Хэдийгээр эгч, дүүс ч гэсэн нэг эхээс төрөөгүй бол энэ асуултанд хамаарахгүй гэдгийг анхаар. МЭДЭХГҮЙ (98) гэсэн хариултыг зөвхөн судалгаанд хамрагдагч өөрөө болон бусдыг төлөөлөн хариулт өгөх эрхтэй хүнийг хэлсэн тохиолдолд л хүлээн ав.

**ММ6- Та 15 болон түүнээс дээш насны хэдэн эгч, дүүтэй вэ ?**

Үүнд 15 болон түүнээс дээш насны одоо амьд сэрүүн байгаа болон 15 болон түүнээс дээш насандаа нас барсан эгч, дүү хамаарна. Энэ асуултын хариулт нь 5-р асуултын хариултаас бага байх ёстой.

**ММ7- 15 ба түүнээс дээш настай эгч, дүү нараас тань хэд нь одоо амьд сэрүүн байгаа вэ?**

15 болон түүнээс дээш насны эгч дүүсээс (эмэгтэй) одоо амьд сэрүүн байгааг асууж, тоог (нийлбэрийг) бич. Байхгүй бол 00 гэнэ. МЭДЭХГҮЙ (98) гэсэн хариултыг зөвхөн судалгаанд хамрагдагч өөрөө болон бусдыг төлөөлөн хариулт өгөх эрхтэй хүнийг хэлсэн тохиолдолд л хүлээн авна.

**ММ8- 15 ба түүнээс дээш настай эгч, дүү нараас тань хэд нь нас барсан бэ?**

15 болон түүнээс дээш насандаа нас барсан эгч, (эмэгтэй)дүүсийн тоог (нийлбэрийг) бич. Тайлбар: 8-р асуултын хариулт нь 6-р асуултын хариулттай ижил буюу түүнээс бага байна. МЭДЭХГҮЙ (98) гэсэн хариултыг зөвхөн судалгаанд хамрагдагч өөрөө болон бусдыг төлөөлөн хариулт өгөх эрхтэй хүнийг хэлсэн тохиолдолд хүлээн авна.

**ММ9- Нас барсан тэдгээр эгч, дүүс нарын хэд нь төрөхийн улмаас (жирэмслэлт, эсвэл хүүхэд төрүүлэх болон төрсний дараахи 6 долоо хоногт) нас барсан бэ?**

Энэ асуултаар 8-р асуултанд өгсөн хариултын дагуу түүний хэд нь дараахи 3 төрлийн үед нас барсныг тодорхойлно. Үүнд: жирэмсэн үедээ, хүүхэд төрүүлэх үед, эсвэл төрсөний дараахи 6 долоо хоногт. Энд хариулагч нь зөвхөн дээрхи гурван шалтгаанаар нас барсан эгч, дүүсээ тодорхойлж хариулахыг анхаар.

## **12. ИН. ӨРХИЙН ОРЛОГО**

Энэ бүлэг

1. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж
2. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ

### 3. Бусад орлого гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ.

#### 1. Цалин, хөлс, тэтгэвэр, тэтгэмж

Энэ дэд бүлэгт өрхийн гишүүдийн цалин, хөлс, шагнал, урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн халамжийн орлого орно. Цалин, хөлсийг бэлэн авсанаар тодорхойлно. Мөнгөн бус хэлбэрээр олгогдсон цалин, хөлс, шагнал, урамшууллын үнийн дүнг мөнгөн хэлбэрээр авсан дүнтэй нийлүүлэн нэгдсэн дүнг орлого, төгрөгөөр гэсэн баганад нөхнө.

#### 2. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогод мал аж ахуйн, газар тариалангийн, бусад үйлдвэрлэл, үйлчилгээ (арилжаа, наймааны орлого энд хамаарна)-ээс олсон цэвэр ашгийн дүнг бичнэ. Хувиараа хөдөлмөр эрхэлсний орлогод орлого олох зорилгоор хувиараа (өрхийн бусад гишүүдтэй хамтарсан болон хамтраагүй байж болно) болон бусадтай хамтран тогтмол болон түр хугацааны ажил хийх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх замаар олсон орлогын дүнгээс үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад гарсан зардлын дүнг хассан дүнг бичнэ. Өөрөөр хэлбэл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсанаас олох цэвэр ашгийн хэмжээ буюу тухайн өрхийн гишүүдийн өөрсдийн хувийн хэрэгцээнд зарцуулахад бэлэн байгаа мөнгөн дүнг энэхүү хэсгийн орлого, төгрөгөөр гэсэн баганад бичнэ.

#### 3. Бусад орлого

Өрхийн үл хөдлөх үндсэн хөрөнгийн орлого, өрхийн гишүүдэд гадаад болон дотоодоос шилжүүлсэн мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж, нөхөн олговор, бусад тусламжууд, үйлдвэрлэлийн бус зориулалтаар бусдаас авсан зээл, хадгаламжинд байгаа мөнгөний хүү (хадгаламжаас тооцож авсан бол), хадгаламжаас авсан мөнгө, даатгалын нөхөн төлбөр, оюуны өмч, патент, зохиогчийн эрх эзэмшснээс олох орлогын хэмжээ болон бусдад зээлдүүлсэн мөнгө, түр хэрэглүүлсэн зүйлийн хүү, түрээс г,м орлогууд хамаарна.

Үл хөдлөх хөрөнгийн орлогод бусдад түрээслүүлсэн үл хөдлөх хөрөнгийн түрээс, оюуны өмчийн орлогод орчуулга хийсний, илтгэл бэлтгэсэн, тавьсан, ном, зохиолын мөнгө г.м орлогууд хамаарна.

#### 13. I.8. Иоджуулсан давсны хэрэглээ.

*Судалгаанд хамрагдсан өрхийн хүнсэндээ хэрэглэж байгаа давсны найрлага, иоджуулалтын түвшинг тогтооно.*

**Асуулт 1** *Танай хүнсэндээ хэрэглэж буй давсны иоджуулалтын байдлыг шалгаж үзье.*

Давсыг шинжлэхдээ энэ талаар өгсөн сургалтын зааварчилгыг баримтлах ба шинжилгээний дүн сөрөг (тухайлбал иодын агуулга нь 0PPM үзүүлэлттэй эсвэл ямар ч өнгөгүй байсан) байвал 1-ийн тоог дугуйл (энэ нь иоджуулаагүй давс болно). Хэрэв шинжилгээгээр иодын агуулга нь 15 PPM-ээс доош байвал (өнгө муутайбайна) 2-ын тоог дугуйл. Шинжилгээний дүн эерэг (15 PPM ба түүнээс дээш мөн тод өнгөтэй байсан) бол 3-

ын тоог дугуйл. Тухайн айлд давс байхгүй бол `хамааралгүй` гэсэн утгатайгаар 8-ын тоог, давс байгаад түүнийг ямар нэгэн шалтгаанаар шинжлүүлээгүй бол 9-ийн тоог тус тус дугуйл.

Ярилцлагаа дуусгаад өрхийн гишүүдэд талархал илэрхийлнэ.

## Судалгааны асуулгын Маягт. ХХС-2.

### 1. WM. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТАЛААРХИ АСУУЛГА

Ярилцлага авагч нар энэ бүлгийн асуулгыг бүрэн авахын тулд асуулгад хариулагч нартай маш эелдэгээр харьцаж, асуулгыг эхлэхийн өмнө боломжтой бол өрхийн бусад гишүүдийг гэрээс түр гарч байхыг хүснэ. Ярилцлага авах үед тав хүртэлх насны хүүхдүүдийн төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн дэвтэр зэрэг бичиг баримтууд шаардлагатай болно. Иймд асуулгыг эхлэхийн өмнө дээрхи бичиг баримтыг бэлтгэсэн байхыг эх/асрагчаас хүснэ.

**Энэхүү асуулгад тухайн өрхийн 15-49 насны нийт эмэгтэйчүүдийг хамруулна. Өрхийн асуулгын багана HL6-д бичигдсэн жагсаалтыг хар. Энэхүү жагсаалтанд бичигдсэн 15-49 насны эмэгтэй тус бүрээр асуулгын маягтыг асууж нөхнө.**

**WM1. Түүврийн нэгжийн дугаар.** Үндэсний статистикийн газраас өгсөн дугаарыг багийн ахлагчаас авч бичнэ.

**WM2. Өрхийн дугаар.** Үндэсний статистикийн газраас өгсөн дугаарыг бичнэ.

**WM3. Эмэгтэйн нэр.** Судалгаанд хамрагдаж буй эмэгтэйн нэрийг өрхийн асуулгын “Өрхийн ам бүлийн байдал” HL бүлгийн 2-р баганаас хуулж бичнэ.

**WM4. Мөрийн дугаар.** Эмэгтэйн мөрийн дугаарыг `Өрхийн ам бүлийн байдал HL дэд бүлгийн HL1-р баганын дугаарыг энд бичнэ.

**WM5, WM6-д** Ярилцлага авагч өөрийн нэр, тоологчийн код, асуулга авсан он сар өдрийг бичнэ. Судалгааны ахлагчаас ярилцлага авагчид хувийн дугаар өгөх бөгөөд энэ нь тоологчийн хувийн дугаар болно.

**WM7.** Ярилцлага хийж асуултыг бүрэн нөхсөний дараа “ярилцлагын үр дүн” хэсгийг нөхнө.

**WM8. Та хэдэн оны хэдэн сард төрсөн бэ?**

Эмэгтэйн төрсөн он, сарыг асууж, асуулгын маягтанд нөхөхдөө эхлээд он, дараа нь сарыг бич. Хэрэв тухайн эмэгтэй төрсөн он, сараа тодорхой мэдэхгүй бол 9998, 98 гэсэн тоог дугуйлж, WM9 асуултыг асууж түүний насыг бич.

**WM9. Та хэдэн настай вэ?**

Насыг асууж бүтэн насаар бичнэ өөрөөр хэлбэл өнгөрсөн төрсөн өдрөөрөө хэдэн нас хүрсэн, тэр насыг бичнэ. Жишээ нь: Судалгаа 2005 оны 11 сард явагдаж байгаа тохиолдолд 1970 оны 12 сард төрсөн эмэгтэй бүтэн 35 нас хүрээгүй байх тул бүтэн насыг 34 гэж бичнэ.

Хүмүүс насаа хэлэхдээ хий насаа нэмдэгийг сайтар анхаар.

**WM10. Та сургуульд сурч байсан уу?** Бага сургуулиас эхлэн бүх шатны сургууль, албан бус сургалт, шашны сургуулийг хамаарна.

Ямар нэгэн сургуульд сурч байгаагүй тохиолдолд '2' гэсэн кодыг дугуйлж асуулт WM14-рүү очно.

**WM10-12** нь Өрхийн гишүүдийн боловсролын байдал ED2-ED4 асуултын хариулттай адил байх ёстой. Энэ бүлэгт өмнөх хариултыг бататгах зорилгоор орсон байгаа.

**WM13.** Асуулт WM11-ыг шалгаж хэрэв хариулагч албан бус сургалт, шашны сургууль мөн ЕБС-ийн сургуулийн 1-4-р анги төгссөн гэж хариулбал асуулт WM14-рүү очно.

**WM14.** Бичиг үсгийн мэдлэгийг шалгах зорилгоор зөвхөн бага сургууль, албан бус болон шашны гэх мэт сургууль дүүргэсэн хүмүүсээс асуулгад байгаа өгүүлбэрийг уншуулж бичиг үсгийн мэдлэгийг тодорхойлж 1-5 хариултын тохирохыг дугуйлна. Өгсөн өгүүлбэрийг уншиж чадахгүй хүн эсвэл хараа муутай, хэлгүй, харж ярьж чадахгүй байвал 5 гэсэн кодыг дугуйлна.

## 2. СМ. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ.

**(Энэ бүлгийг 15-49 насны эмэгтэйчүүдээс асууна).**

Энэ бүлгийн асуулт зөвхөн амьд төрөлтөд хамаарна. Энд дутуу төрөлт, үрчилсэн хүүхэд, дагавар хүүхдийг оруулахгүй, зөвхөн тухайн эмэгтэйн өөрийнх нь төрүүлсэн хүүхдийн талаар асууж байгааг онцгой анхаарч сайтар тайлбарла.

Энэ бүлгийн асуултуудаар эмэгтэйн төрөлтийн талаарх мэдээллийг цуглуулж, үүнийг үндэслэн хүүхдийн эндэгдлийн түвшинг тодорхойлох зорилготой.

**СМ1. Та хүүхэд төрүүлж байсан уу?**

Хүүхдийн эндэгдэл болон асуулгын зарим бүлгийн мэдээллийг тухайн эмэгтэйгээс авах эсэхийг тодорхойлоход энэ асуулгыг ашиглана. Хэрэв тэр эмэгтэй Тийм гэж хариулбал 1-ийн тоог дугуйлаад 2-р асуулт руу очно. Хэрэв тэр эмэгтэй Үгүй (2), би хэзээ ч хүүхэд төрүүлж байгаагүй гэж хариулсан тохиолдолд тэр эмэгтэй амьд төрөлт гэдгийг зөв ойлгосон эсэхийг шалга. *Жишээ нь төрсөний дараа өчүүхэн богино хугацаагаар ч гэсэн амьсгалж, чарлаж байсан хүүхдийн талаар л би ярьж байна..* гэх мэтээр тодруулна. Хэрэв Үгүй гэж хариулсан хэвээр бол 2-ын тоог дугуйлж, энэ бүлгийн бусад асуулгыг асуулгүйгээр орхиж, гэрлэлтийн талаарх мэдээлэл гэсэн дараагийн бүлэг рүү очно.

Наад зах нь нэг удаа төрсөн эмэгтэйчүүдээс дараагийн асуултыг асууна (Хүүхэд эсэн мэнд байгаа эсэхээс үл хамаарна).

**СМ2а. Та анхны хүүхдээ хэдэн онд төрүүлсэн бэ?**

Анхны төрөлтийн он, эсвэл анхны хүүхдийн төрсөн оныг тогтоохын тулд боломжтой бүх асуултыг тавьж шалга. Тухайн эмэгтэй анхны хүүхдээ төрүүлсэн хугацаагаа сайн мэдэж байвал он, сар, өдрийг асуугаад эхлээд төрүүлсэн он, дараа нь сар, өдрийг бич. Харин анхны төрөлтийн хугацаагаа мэдэхгүй бол 9998, 998, 98-ийн тоог дугуйл.

**СМ2b. Хэдэн жилийн өмнө анхны хүүхдээ төрүүлсэн бэ?**

Түүний анхны төрөлтийн хугацааг тодорхойлохын тулд Та хэдэн жилийн өмнө анхны хүүхдээ төрүүлсэн бэ? гэж асуугаад судалгаа авч байгаа өдрөөс урагш нь тоолж бүтэн жилийг тодорхойлон бич.

**СМ3. Төрүүлсэн хүүхдүүд тань одоо Таньтай хамт амьдардаг уу?**

Төрүүлсэн охид, хөвгүүдээс одоо эхтэйгээ хамт амьдарч байгаа эсэхийг асуугаад хүүхдүүдээс нь хамт амьдарч байгаа бол “1” гэсэн кодыг, хүүхдүүдийн хэн нэг нь хамт амьдардаггүй бол “2” гэсэн кодыг дугуйлж, дараагийн асуултыг алгасч асуулт СМ5 руу оч. Алгассан асуултыг зурж тэмдэглэ.

**СМ4. Таны төрүүлсэн хүүхдүүдээс хэдэн хүү/охин таньтай хамт амьдардаг вэ?**

Хүүхдүүд нь эхтэйгээ хамт амьдардаг гэж СМ3 асуултанд хариулсан тохиолдолд түүний төрүүлсэн хэдэн хүүхэд эхтэйгээ хамт амьдарч байгааг асууж, хамт амьдарч байгаа хүү, охидын тоог тус тусад нь бич. Хэрэв тухайн эх хүү (охин) төрүүлээгүй, эсвэл төрүүлсэн хүү (охин) нь хамт амьдардаггүй бол хамт амьдардаг хүүгийн (охидын) тоог бичих газарт 00 гэж бичнэ. Энд бид тухайн эмэгтэйн зөвхөн өөрийнх нь төрүүлсэн хүүхдийн талаар ярилцаж байгаа гэдгийг санаарай. Бусдаас үрчилж авсан эсвэл дагавар хүүхэд энд хамаарахгүй.

**СМ5. Таны төрүүлсэн хүүхдүүдээс тусдаа амьдардаг хүүхэд бий юу?**

Төрүүлсэн хүүхдүүдээс нь одоо эсэн мэнд байгаа гэхдээ эхтэйгээ хамт амьдардаггүй хүү, охидын талаар асууна. Хүүхдүүд нь хамаатан, төрөл садныдаа тусдаа амьдардаг, эсвэл бусдад өргүүлсэн мөн өсөж том болоод өрх тусгаарласан байж болно. Хамгийн гол нь энд эндсэн, нас барсан хүүхдийг хамруулахгүй. Энэ асуултанд Байхгүй гэж хариулбал асуулт СМ6-г алгасч, асуулт СМ 7-г асууна. Алгассан асуултыг зурж тэмдэглэ.

**СМ6. Таны төрүүлсэн хүүхдүүдээс хэдэн хүү/охин таниас тусдаа амьдардаг вэ?**

Хэрэв асуулт 5-д Тийм гэж хариулсан бол эхээсээ тусдаа амьдардаг хүү, охины тоог асууж, хүү, охиноор нь ялган бич. Хэрэв тухайн эх нь хүү (охин) төрүүлээгүй, эсвэл төрүүлсэн хүү (охин) нь хамт амьдардаг бол хамт амьдардаггүй хүүгийн (охидын) тоог бичих газарт 00 гэж бичнэ. Энд бид тухайн эмэгтэйн зөвхөн өөрийнх нь төрүүлсэн хүүхдийн талаар ярилцаж байгаа гэдгийг санаарай. Бусдаас өргөж авсан эсвэл нөхрийн дагавар болон бусад хүүхэд энд хамаарахгүй.

**СМ7. Амьд төрөөд эндсэн хүүхэд бий юу?**

Таны төрүүлсэн хүүхдүүдээс (хүү, охин) тодорхой хугацаагаар амьдраад нас барсан хүүхэд бий юу гэж асууна. Нас барсан хүүхдийн талаар асуух хэцүү боловч энэ асуултыг зайлшгүй асуух шаардлагатай. Ярилцлага өгч эх багадаа эндсэн хүүхдийг энд оруулахгүйгээр “Үгүй” гэж хариулж болох учир төрөөд **хэдхэн цаг, өдөр (хэдхэн хором) амьдарсан эсвэл төрснийхөө дараа уйлж, хөдөлж байгаад** эндсэн хүүхэд байсан уу гэж тодруулан асууж, шалгах. Зарим тохиолдолд энэ асуултад хариулахыг хүсэхгүй байх мөн бусдыг хүнд, эвгүй байдалд хүргэж болно. Ийм тохиолдолд энэ асуултанд хариулахад үнэхээр хүнд, хэцүү

зүйл гэдгийг ойлгож байна, гэхдээ манай судалгаанд их чухал ач холбогдолтой гэдгийг хэлж тайлбарла.

**СМ8. Хэдэн хүүхэд эндсэн бэ ?**

Хэрэв СМ7-р асуултанд Тийм гэж хариулсан бол энэ асуултыг асууж эндсэн хүү, охины тоог бич. Хэрэв эндсэн охин, хүү байхгүй, мөн ерөөсөө охин, хүү төрүүлээгүй бол холбогдох мөрөнд 00 гэж бич.

**СМ9.10 Бүгд хэдэн хүүхэд төрүүлсэнийг ярилцлага авагч өөрөө дүгнэж бичнэ.** 4,6 болон 8-р асуултын хариултад бичигдсэн тооны нийлбэрийг энд бичнэ. Та амьдралынхаа хугацаанд \_\_ хүүхэд (төрүүлсэн хүүдүүдийн тоог нэмж гарга) төрүүлсэн байна . Энэ зөв үү? гэж хариулагчаас хүүхдийн тоо зөв эсэхийг лавлаж асууна. Хэрэв Буруу байна гэвэл эхлээд нийлбэрийг шалга, дараа нь өмнөх асуултын хариултыг шалга. Жишээлбэл асуулт 4-өөс эхлэн асуух **Таны 2 хүү, 1 охин таньтай хамт амьдарч байна, энэ зөв үү?** гэх мэтээр 6 ба 8 -р асуултыг асууж хяна. Хариулт зөв бол асуулт **СМ9**-д нийлбэр дүнг шалгаад, дараа нь асуулт СМ11- рүү очно.

**СМ11 Та ... удаа төрсөн байна. Хамгийн сүүлчийн хүүхдээ хэзээ төрүүлсэн вэ? Сүүлчийн хүүхэд одоо эсэн мэнд байгаа эсэхээс үл хамаарна.**

Энэ асуулгаар эмэгтэйчүүдээс дараагийн бүлгийн асуултыг асуух шаардлагатай эсэхийг тодорхойлно. Иймээс эмэгтэй сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эсэхийг лавлан асууж, хүүхэд төрүүлсэн бол асуултыг цааш үргэлжлүүлэн асууж, хэрэв энэ хугацаанд хүүхэд төрүүлээгүй бол гэрлэлтийн талаарх асуултыг (**МА** бүлэг) асууна.

**СМ12** Тухайн эмэгтэйн сүүлийн төрөлт нь манай судалгааны ярилцлага авч байгаа өдрөөс өмнөх 2 жил буюу 2003 оны.....сарын .... өдрөөс хойш болохыг шалгах, хэрэв хүүхэд нь эндсэн бол эх, нялхсын эрүүл мэндийн (MN бүлэг) асуултыг асуухдаа хүүхдийн нэрийг хэлж асуухаас зайлсхийж болгоомжтой хандах хэрэгтэй.

**СМ13. Та энэ жирэмслэлтийг хүсч байсан уу?**

Сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн бол Та энэ хүүхдээ төрүүлэхийг төлөвлөж байсан уу эсвэл хожим төрүүлэхээр төлөвлөж байсан уу гэж асуун тохирох хариултыг дугуйлна.

**3. MN. ЭХ, НЯЛХСЫН ЭРҮҮЛ МЭНД**

*Энэ бүлгийн асуулгаар эх болон шинэ төрсөн хүүхдийн эрүүл мэндийн талаархи мэдээллийг цуглуулах зорилготой. Тэгэхээр эхийн эрүүл мэндийн байдал, жирэмсний хугацаанд болон төрөлт, төрсний дараа эхийн эмнэлэгт үзүүлж, эрүүл мэндийн үйлчилгээ хэрхэн авч байсан талаар асууна. Мөн хүүхдийн төрөх үеийн жинг асууна.*

***MN1. Та сүүлийн хүүхдээ төрүүлсэний дараахи эхний хоёр сард Та "А" амин дэмийг ийм тунгаар уусан уу?***

200,000 нэгжийн тун эсвэл ийм хэмжээний тунгийн сав, хайрцгийг үзүүлж асуу. Хэрэв нэг капсулаас илүү хэмжээгээр хэрэглэсэн бол А витаминь бусад загвараас үзүүлж ярилц. Тогтоосон тунгийн хэмжээ нэг эмэгтэйд 200,000 нэгж байх ёстой. Амин дэм "А"-г эхэд уулгаж улмаар түүгээр дамжуулан түүний тээж байгаа нялхасд хүргэх нь эх, нялхсын эрүүл мэндийн байдлыг сайжруулна. Эхийг эргэж сануулахын тулд капсултай витаминь үзүүл. Ингээд эхийн өгсөн хариултын дагуу тохирох кодыг дугуйл.

***MN2. Төрөхөөсөө өмнө Та эмчид үзүүлж байсан уу?***

Жирэмсэн эмэгтэй болон төрөх хүүхдийн талаархи эмнэлгийн шинжилгээ нь хүүхдийг тээх болон төрүүлэх үеийн хүндрэлтэй асуудлыг шийдэхэд тустай. Иймээс жирэмсэн эх бүр эрүүл мэндээ хянуулж, шинжилгээ өгч байх ёстой. Эхийн зөвхөн жирэмсний хугацаандаа шинжилгээ өгч, эмнэлэг, эмчийн хяналтанд орсон, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдлыг тодруулна. Энэ асуулт нь хоёр хэсгээс бүрдэнэ. Учир нь `эмчид үзүүлж байсан` гэсэн хариулт өгсөн эмэгтэйчүүдээс хэнд үзүүлж, хяналтанд орсоныг асуу. Гэхдээ нэг биш хэд хэдэн эмч, сувилагчид үзүүлсэн байвал тэр үзүүлсэн хүн бүрийн холбогдох хариултын кодыг дугуйл. Хэрэв энэ эмэгтэйн хандсан эмнэлэг болон эмч тодорхой бус бол тодруулж асуугаад `бусад` гэсэн хэсэгт хамааруулж Х-ийг дугуйлах ба чухам хаана, хэнд үзүүлсэнийг бич. Харин энэ эмэгтэй хэнд ч, хаана ч үзүүлээгүй бол Ү-г дугуйлна.

***MN3-MN6.*** Энд жирэмсний хяналтанд байх явцад биеийн жин, даралтаа хэмжүүлэх, шээсний болон цусны шинжилгээ өгөх, ДОХ өвчин болон Хүний дархлал, хомсдолын вирус (ХДХВ)-ын сорил өгсөн үгүйг нэг бүрчлэн асууж холбогдох кодыг дугуйлна.

***MN7. Таны сүүлийн хүүхэд (нэр)-ийг хэн эх барьж авсан бэ?***

Хэрэв тухайн эх өөрийнхөө төрөлтийн үед анхны тусламж үзүүлсэн эмч, сувилагч, бариач хэн болохыг сайн мэдэхгүй бол цаашид лавлаж шалга. Төрөлтийн үед эмнэлгийн тус дэмжлэг үзүүлсэн бүх хүнийг сайн лавлах, асуух. Хэрэв Та тэр хүнийг хаана хамруулахыг тодорхой мэдэхгүй тохиолдолд `Бусад` -д хамруулж Х гэсэн шифрийг дугуйлна.

***MN8. Та хүүхдээ хаана төрүүлсэн бэ?*** Хүүхдээ хаана төрүүлсэнийг тодорхойлж тохирох кодыг дугуйл. Хэрэв эмнэлэг, эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг бол нэрийг бичнэ.

***MN9. Таны сүүлийн төрүүлсэн хүүхэд хэр зэргийн жинтэй төрсөн бэ? (хүүхдүүдийн ерөнхий дундаж хэмжээтэй харьцуулж тодорхойлно).***

Зөвхөн эхийн бодлоор тодорхойлно. Дундаж жингээс бага жинтэй төрсөн хүүхэд нь бусдыг бодвол хүнд өвчинд нэрвэгдэх, эндэх магадлал өндөр байдаг. Хүүхдийг төрөх үед түүний биеийн жинг хэмжсэн эсэхийг эхчүүдээс асууна. Энэ асуулт нь эхчүүд өөрөө ямар жинтэй хүүхэд төрүүлсэн гэж бодож явдаг талаархи тэдний бодлыг мэдэх боломжийг олгоно.



Асуулганд хариулт авахын өмнө судалгааны асуулгыг сайтар унш. Эмэгтэйн төрүүлсэн хүүхдийн биеийн хэмжээний талаархи санал бодол нь тухайн эмэгтэйн хувь хүнийх нь өөрийн ойлголт болно. Хэдийгээр эх хүүхдийнхээ төрөх үеийн жинг мэддэг байсан ч Та тэр эмэгтэйн хувийнх нь бодлыг асуу. *Жишээ нь: өөрийнхөө хүүхдийг маш том, том, дундаж, маш жижиг` гэх мэтээр хэлж болно. Холбогдох кодыг дугуйлна.*

***MN10. Танай хүүхдийг төрөхөд биеийн жинг нь хэмжсэн үү?***

Хэмжсэн (1), хэрэв хүүхдийг төрөх үед нь жигнэж хэмжээгүй (2), эх нь хүүхдийнхээ жинг хэмжсэн эсэхийг мэдэхгүй (8) гэж холбогдох кодыг дугуйл.

***MN11. Хүүхэд ямар жинтэй төрсөн бэ?***

Хүүхдийг төрсний дараа жигнэсэн бол биеийн жингийн хэмжээг `килограммаар` бичнэ.

Хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр гэртээ байгаа тохиолдолд дэвтрээс харж 'картад бичсэнээр' гэсэн хариулт дээр '1'-ийг дугуйлж, хүүхдийн жинг бичнэ.

Эрүүл мэндийн дэвтэр байхгүй тохиолдолд 'эхийн хэлснээр' гэсэн хариулт дээр '2'-ыг дугуйлж, хүүхдийн жинг бичнэ. Жинг бичихдээ 3 кг 200 гр гэж хэлбэл '**3.200**' гэж бичнэ.

Хэрэв хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр байхгүй, эх нь хүүхдийнхээ төрөх үеийн жинг мэдэхгүй тохиолдолд `99998` гэсэн хариултыг дугуйл.

***MN12. (нэр) хөхөөр хооллосон уу?***

Хүүхдийн эрүүл мэнд, өсөлтөд хөхөө хөхөх нь ихээхэн чухал. Энэ асуултын хувьд хүүхэд хөхөө хөхсөн үү гэдгийг голчлон асууна, харин хэр удаан хугацаад гэдэг нь чухал биш гэдгийг анхаар. Түүнчлэн хүүхэд төрөөд удалгүй эндсэн байсан ч асуултыг тавина.

Тийм, Үгүй гэсэн хоёр хариултаас тохирохыг дугуйлж 'Үгүй' гэвэл дараагийн бүлэг МА-рүү очно.

***MN13. Төрсний дараа (нэр)-ийг хэр удаж амлуулсан бэ?*** гэсэн асуултад 'Тэр дороо амлуулсан' бол '000' гэсэн кодыг дугуйлна. Хэрэв амлуулсан бол 1 –ийг дугуйлж ард нь 00 гэж бичих бөгөөд 24 цагийн дотор бол 1-ийг дугуйлан цагийн тоог тавина. Харин бусад тохиолдолд амлуулсан хугацааг өдрөөр гаргаж өдрийн тоог бичээд 2 -ыг дугуйлна.

#### **4. МА. ГЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Энэ бүлэгт 15-49 насны бүх эмэгтэйчүүдийг хамруулж асууна. Өрхийн 15-аас дээш насны гишүүдийн гэрлэлтийн байдлыг асууж хүснэгтэд өгөгдсөн тохирох кодыг дугуйлна.

Гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлсэн болон албан ёсоор гэрлээгүй боловч хамт амьдарч байгаа хүмүүсийг аль алиныг нь гэр бүлтэй гэдэгт хамруулна.

Эмэгтэй найз залуутай боловч түүнтэйгээ хамт амьдардаггүй бол хамтран амьдрагч гэж үзэхгүй.

***МА1. Та одоогоор гэр бүлтэй юү эсвэл хамтран амьдрагчтай юу?***

Энэ асуултад одоогоор баталгаатай гэр бүлтэй, хамтран амьдрагчтай эсвэл ганцаар амьдардаг (нөхөр, хамтран амьдрагчгүй) гэснийг хэлсэн хариултын кодыг дугуйлна. Хэрэв

эмэгтэй одоогоор нөхөр, хамтран амьдрагчгүй бол '3' гэсэн кодыг дугуйлж асуулт МА3-руу очно.

**МА2. Таны нөхөр (хамтран амьдрагч) хэдэн настай вэ?**

Эмэгтэй нөхөр (хамтран амьдрагч)-ийнхөө насыг мэдэж байвал насыг тэмдэглэх тусгай зайд (бүтэн насаар) бичнэ. Хэрэв мэдэхгүй бол "98" кодыг дугуйлаад асуулт МА5-руу очно.

**МА3. Та ер нь хүнтэй гэр бүл болж байсан уу эсвэл хамтран амьдрагчтай байсан уу?**

Одоогоор гэр бүлгүй болсон, хамтран амьдарч байгаагүй, салсан, бэлэвсэн эмэгтэйгээс ер нь хүнтэй гэрлэж байсан болон хамтран амьдарч байсан эсэхийг асуу. "Гэрлэлт" –д албан ёсны болон албан бус гэрлэлт аль аль нь хамаарахыг анхаар.

Өгсөн хариултын кодыг дугуйл. Энд тийм гэсэн хариултанд хоёр өөр хариултын төрөл байгааг анхаарах. Тийм гэж хариулсан бол: Тийм, баталгаатай байсан, Тийм, баталгаагүй байсан гэдгийг ялгаж тэмдэглэнэ.

Энэ хоёр төрлийн хариултын хоорондын ялгааг шалга. Хариулагч зөвхөн тийм гэж хариулбал Та баталгаатай гэр бүлтэй байсан уу? эсвэл баталгаагүй байсан уу? гэж асууна. Хэрэв эмэгтэй гэрлэж байгаагүй, хамтран амьдрагчтай байгаагүй гэж хариулсан бол 3 гэсэн кодыг дугуйлж, МА 8а руу шилжинэ. Бусад тохиолдолд МА4 –ийг үргэлжлүүлэн асууна.

**МА4. Таны гэрлэлтийн одоогийн байдал?**

Энэ асуултыг одоогоор гэр бүлгүй боловч өмнө нь гэрлэж (албан, албан бус аль аль нь орно) байсан хүнээс асууж байгаа учраас **"Та бэлэвсэн үү, салсан уу, тусгаарласан уу?"** гэж асууж болно.

Энд *"Бэлэвсэн"* гэдэгт эмэгтэйн сүүлийн нөхөр нь нас барсан, *"Салсан"* гэдэгт эмэгтэй сүүлийн нөхрөөсөө гэрлэлтээ цуцлуулсан, харин *"Тусгаарласан"* гэдэгт нөхөртэйгээ хамт бус, тусдаа амьдарч байгааг хамааруулна.

**МА5. Та хэдэн удаа гэр бүл болж, хамтран амьдрагчтай байсан бэ?**

Асуулт МА1–ээр бид албан ёсны, түүнчлэн албан бус гэрлэлт сонирхсон байгаа. Албан ёсны гэрлэлт гэдэг нь гэрлэлтийн баталгаатайг албан ёсны бус гэдгийг гэрлэлтийн баталгаагүй гэр бүлийг хэлнэ.

Хэрэв тухайн эмэгтэй гэрлэсэн болон хамтран амьдарч байгаад бэлэвсэрсэн, салсан, тусгаарласан боловч одоогоор хэн нэгэнтэй гэрлэж эсвэл хамтран амьдарч байгаа бол МА-5-д '1-ээс дээш удаа' гэдэг хариултын '2' кодыг дугуйлна.

Хэрэв тухайн эмэгтэй нэг удаа гэрлэсэн /хамтран амьдрагчтай/ бол зөвхөн нэг удаа буюу "1" гэсэн кодыг дугуйлна.

Энэ асуулт гэр бүл болсон, хамтран амьдарсан хугацаанд хамааралтай бөгөөд нөхөр, хамтран амьдрагчийн тоонд хамааралгүй гэдгийг анхаарах. Хэрэв эмэгтэй нөхрөөсөө салаад эргээд түүнтэйгээ суусан бол эмэгтэйг "1-ээс дээш удаа" гэрлэсэн гэсэнд хамааруулна.

**МА6. Та анх хэзээ гэр бүл болсон эсвэл хамтран амьдрагчтай болсон бэ?**

Хариулагч анхны гэрлэлт болон хамтран амьдарч эхэлсэн хугацаагаа мэдэж байвал хугацааг “он”, “сар” гэсэн тохирох зайд сарыг цифрт шилжүүлэн бичнэ. Нэгдүгээр сар “01”, гуравдугаар сар “3” гэх мэт.

Анхны гэрлэлт болон хамтран амьдарч эхэлсэн хугацааг эмэгтэй санахгүй бол хугацааг тодорхойлсон ямар нэг баримт бичиг байгаа бол үүнийгээ харахыг зөвлөнө. Байхгүй бол сараа мэдэхгүй буюу “98” гэсэн кодыг дугуйлан жилийг асууна. Жилийг мэдэж байвал тохирох зайд оныг бичнэ. Мэдэхгүй бол дээрхтэй адилаар баримт бичиг байгаа эсэхийг асууж оноо мэдэхгүй буюу “9998” гэсэн кодыг дугуйлна.

**МА7. Шалга МА6:**

Сар, он хоёр мэдэгдэж байвал дараагийн бүлэг **СР**-рүү шилжинэ. Сар, жил хоёулаа мэдэгдэхгүй бол МА8-ийг үргэлжлүүлэн асууна.

**МА8. Та анхныхаа нөхөр эсвэл хамтран амьдрагчтай хэдэн настайгаасаа хамт амьдарч эхэлсэн бэ?**

Хэрэв мэдэхгүй бол насны талаар асуусан өөр асуултаар тандах. Жишээлбэл, анхны хүүхдээ төрүүлэхдээ хэдэн настай байсан, төрөхөөс өмнө болон төрсний дараа хэр удаж хамтран амьдарч эхэлсэн гэх мэтээр тандах. Асуултыг нөхөхгүй орхиж болохгүй.

**МА8а. Та анх хэдэн настайдаа бэлгийн харьцаанд орсон бэ?**

Энэ асуултыг асуухын өмнө хариулагчийн дэргэд гадны хүн байгаа эсэхийг шалга! Хариулагчийн нууцыг хадгалах үүднээс гадны хүмүүс дэргэд нь байвал дуугаа намсгаж болгоомжтой асуу.

Мөн эмэгтэйн нас, гэрлэлтийн байдлын талаарх хариултуудыг харгалзан зарим үед **“Хэрэв та бэлгийн харьцаанд орсон бол анх удаа бэлгийн харьцаанд орохдоо хэдэн настай байсан бэ?”** гэж асуу.

Бэлгийн харьцаанд огт ороогүй бол 00-ыг дугуйлж, орсон бол насыг **бүтэн** насаар бичнэ.

Хариулагчийн өгсөн мэдээлэл нь зөвхөн статистикийн судалгааны зорилгоор ашиглагдах бөгөөд таны нэрээр мэдээлэл хаана ч тархаагдахгүй гэдгийг сайн тайлбарлах хэрэгтэй.

**5. СР. ЖИРЭМСЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА, ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ**

*Энэ бүлгийн асуулгаар жирэмслэхээс урьдчилан сэргийлэх арга, хэрэгслийг хэрэглэж байгаа түвшин болон хэрэглэж байгаа аргын төрлийн талаархи мэдээллийг цуглуулна. Энэ бүлгийн асуулганд 15-49 насны гэрлэсэн болон хамтын амьдралтай эмэгтэйчүүдийг хамруулна.*

Энэ бүлгийн болон ДОХ өвчний талаархи дараагийн бүлгийн асуулгууд нь бусдын хувийн асуудлыг нэлээд гүн хөндөх учир судалгааны зохицуулагч, зөвлөх, бүлгийнхэн энэ асуулгыг хэрхэн яаж танилцуулах талаар ярилцаж, анхаарах шаардлагатай. Ярилцлага

авагч нар энэ эмзэг асуулгыг бүрэн авах талаар мэргэшсэн байх хэрэгтэй. Иймээс ярилцлага авагч нар нь эмэгтэй хүн байх нь илүү тохиромжтой.

*Ярилцлага авах үед судалгааны багын бүлгийн эрэгтэй гишүүдийг гадагш гарч байхыг шаардах хэрэгтэй.*

**CP1. Та одоогоор жирэмсэн үү?**

Энэ асуултанд холбогдох хариултуудын аль хамаарах шифрийг бич. Тухайн эмэгтэй жирэмсэн гэх хариултыг 1-г дугуйлаад дараагийн асуултыг асууна. Харин Үгүй, мэдэхгүй гэсэн хариулт өгсөн тохиолдолд холбогдох кодыг тэмдэглэх, дараагийн асуулт CP1а-г алгасч, асуулт CP2 руу очно.

**CP2. Та жирэмслэлтээс сэргийлж ямар нэг арга хэрэглэдэг үү?**

Хэрэв `Тийм` гэж хариулбал 1 –ийг тэмдэглэнэ. `Үгүй` гэж хариулсан бол 2 –ыг дугуйлж, асуулт CP3-г алгасан, асуулт CP4а –руу очно.

**CP3. Ямар ямар арга хэрэглэдэг вэ?**

Тухайн эмэгтэйд маягтад байгаа хариултуудыг нэрлэж уншиж өгч болохгүй. Эмэгтэй янз бүрийн хугацаагаар олон төрлийн арга, хэрэгсэл хэрэглэдэг байж болох учир алийг нь гэж тодорхойлж хэлэх нь Таньд хүндрэлтэй байж болно. Иймээс яг одоо хэрэглэж байгаа, мөн тухайн эмэгтэйн хувьд гол гэж үздэг аргыг сонго. Тухайн үед үрэл эм хэрэглэж байсан бол эмийг сонгоно. Бэлгийн харьцаанд орохдоо эр, эм бэлгэвч, спираль г.м олон арга хэрэгслийг хэрэглэдэг. Жирэмслэлтээс хамгаалах өөр аргууд ч байж болно. Жирэмслэлтээс хамгаалах тарилгыг 3-6 сарын өмнөөс хэрэглэдэг, ерөндөг нь 5 жил хүртэл хугацаагаар хэрэглэдэг. Хэрэв эмэгтэйн үрийн хоолойг боох эмчилгээ хийлгэсэн бол А-ийг, хэрэв эрэгтэй нь үрийн сувгийг таслах эмчилгээ хийлгэсэн бол В-г дугуйл. Эмэгтэйг бүү яаруул. Хэрэв энэ асуулгад тусгагдаагүй хариулт (аргыг) нэрлэбэл `Бусад` гэсэн хэсэгт хамруулж, тодруулж бичээд Х-г дугуйл.

**CP4-CP4E.** Эдгээр асуултууд нь эмэгтэйн хүүхэд төрүүлэх хожмын төлөвлөгөө, бодлыг асууж байгаа тул одоо жирэмсэн болон жирэмсэн биш байгаа эсэхээс шалтгаалахгүйгээр төрөх насны, өөрөөр хэлбэл 15-49 настай эмэгтэйгээс аль алинаас нь асууна.

## **6. DV. ГЭР БҮЛИЙН ДОТОРХ ХҮЧИРХИЙЛЛИЙН БАЙДАЛ**

Энэ бүлэг ганц асуулттай бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн талаарх эмэгтэйчүүдийн санал бодлыг судлах зорилготой. Зарим эмэгтэйчүүд нөхөр нь эхнэрээ буруутай тохиолдолд цохиж, зодохыг байж болох зүйл гэж үздэг тал бий. Гэхдээ энэ нь тухайн хувь хүний үзэл бодол эсвэл нийгмийн байдалтай холбоотой байж болох юм.

### **DV1. Заримдаа эрэгтэйчүүд эхнэрийнхээ хийсэн зүйлд уурладаг.**

**Таны бодлоор дараах тохиолдолд нөхөр нь эхнэрээ зодохыг зөвтгөж болох уу?**

DV1A. Гэрээс гарахдаа хэлэхгүй байх

DV1B. Хүүхэддээ анхаарал тавихгүй байх

DV1C. Нөхөртэйгээ маргах

DV1D. Эхнэр нь бэлгийн харьцаанд орохоос татгалзах

DV1E. Хоолоо түлэх

Тохиолдол бүрийг чангаар уншиж өгөөд холбогдох хариултыг дугуйл.

## **7. НА. ДОХ (ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХАМ ШИНЖ), ХДХВ (ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУС) ӨВЧНИЙ ТАЛААРХ МЭДЛЭГ**

*Энэ бүлгийн асуулгад 15-49 насны эмэгтэйчүүдийг хамруулна. Дархлалын олдмол хам шинж өвчний халдвараас хэрхэн сэргийлэх талаар ерөнхий мэдлэгтэй холбоотой асуудлаар мэдээлэл цуглуулах зорилготой.*

### **НА1. ДОХ өвчин ба ХДХВ-ын талаар сонсож байсан уу?**

Энэ талаар огт сонсоогүй бол **НА 19**-рүү оч.

Энэ асуулт болон дараагийн асуултуудаар ДОХ өвчний талаархи үндсэн мэдлэгийн түвшинг тогтоох зорилготой юм..

### **НА2. Зөвхөн нэг хүнтэй бэлгийн харьцаатай байдаг, ДОХ-ын халдвар аваагүй хүнтэй бэлгийн харьцаанд байснаар ХДХВ-ын халдвараас цаашид өөрийгөө сэргийлж болох уу?**

Энэ асуулт нь бэлгийн харьцаатай холбоотой асуулт ч байгаа учир хариулахад хүнд байж болно. Иймээс Та `Тийм(1)` ,`Үгүй (2)` , "Мэдэхгүй (8) гэсэн хариултын аль нэгийг хариулахыг хүсэж байна гээд холбогдох кодыг дугуйл.

### **НА 3. ХДХВ-ын халдвар мухар сүсгээр халдварлана гэж бодож байна уу?**

\*\* Энэ асуулгыг дараахи хэлбэрээр асууж болно: **ДОХ-ын вирус нь ер бусын байдлаар халдварладаг гэж Та бодож байна уу ?** гээд холбогдох кодыг дугуйл.

### **НА4. Бэлгийн харьцаанд орох бүрдээ бэлгээч хэрэглэвэл ХДХВ-ын халдвар авах магадлалыг багасгаж чадах уу?**

Хариулагч эмэгтэй энэ талаар юу гэж үздэг болохыг асууж хариултын дагуу холбогдох кодыг дугуйл.

**НА5. Шумууланд хазуулсаны улмаас ХДХВ халдварлах уу?** Хариултын дагуу холбогдох кодыг дугуйл.

**НА6. Бэлгийн харьцаанд огт орохгүй байснаар ХДХВ-ын халдвар авах магадлалыг багасгаж чадах уу?**

Хариулагчийн хариултыг `зөв, буруу` гэж дүгнэж хариулт өгч болохгүй. Зөвхөн хариулсан хариултын дагуу холбогдох кодыг дугуйл.

**НА7. ХДХВ-ын халдвар авсан хүнтэй хоол хүнсээ хэрэглэснээс ХДХВ халдах уу?**  
Хариулагчийн бодлыг тандан тохирох хариултыг дугуйлна.

**НА8. Эрүүл чийрэг харагдаж байгаа хүн ХДХВ-ын халдвар авсан байж болох уу?**  
ДОХ -оор өвчилсөн болон халдварын вирус/нян/ тээгч нь ямар нэг өвчин, зовиургүй харагддаг гэсэн нийтлэг ташаа ойлголт байдаг. Энэ асуултыг ДОХ өвчин, түүний нянгийн халдварын талаар сонсож байсан гэж хариулт өгсөн эмэгтэй бүрээс асууна. Энэ асуултанд өгөгдсөн хариултын холбогдох кодыг дугуйлна. ДОХ өвчний талаархи нилээд гүнзгий ойлголтыг авч, бэлгийн замаар шууд халдварлах талаар уг эмэгтэй юу мэдэж байгаа эсэхийг НА9-НА12 р асуултаар тодруулна.

**НА9. ХДХВ эхээс хүүхдэд халдварлах уу?**

Жирэмсэн байх үед, төрөх үед, мөн хөхний сүүгээр гэж 3 янзаар асууж холбогдох кодыг дугуйлна.

**НА10. ДОХ-оор өвчлөөгүй боловч ХДХВ-ын халдвар авсан эмэгтэй багш үргэлжлүүлэн ажиллаж болох уу?**

Хариулагч эмэгтэйн бодлыг асууж, өгсөн хариултын дагуу холбогдох кодыг дугуйлна.

**НА11. Ногооны худалдагч ХДХВ-ын халдвар авсан гэдгийг мэдвэл Та тэр хүнээс ногоо худалдаж авах уу?**

Хариулагч эмэгтэй энэ талаар юу гэж үздэг болохыг асууж, холбогдох кодыг тэмдэглэнэ.

Дараагийн 6 асуултаар ДОХ-ын халдвар, өвчний сорилын талаархи мэдлэгийг асууж ` мэдээгүй, тодорхойгүй хэрэгцээ`-ний талаархи мэдээллийг авна.

**НА12.Хэрэв танай гэр бүлийн гишүүдээс хэн нэг нь ХДХВ-ын халдвар авсан тохиолдолд Та үүнийг нууц хэвээр үлдээхийг хүсэх үү?**

Хариулагч эмэгтэйн бодлыг асууж, өгсөн хариултын дагуу холбогдох кодыг дугуйл

**НА13.Хэрэв танай гэр бүлийн гишүүдээс хэн нэг нь ДОХ өвчнөөр өвчилвөл та түүнийг гэртээ асарч сувилахад бэлэн байна уу?**

Хариулагч эмэгтэйн бодлыг асууж, өгсөн хариултын дагуу холбогдох кодыг дугуйл

**НА15. Та ер нь ХДХВ-ын сорил өгч байсан уу? Би сорилын (шинжилгээний хариу, дүнг сонирхоогүй).**

Одоо Танаас бэлгийн замын халдварт өвчин ДОХ-ын талаар асуухгүй, харин ДОХ өвчний болон түүний нянгийн шинжилгээ хийх, зөвлөлгөө өгөх газрын хэрэгцээ, шаардлага хир байгааг сонирхож асууя.

Хэрэв хариулагч шинжилгээ өгч байсан гэж хариулбал 1-ийн тоог бичиж, НА16, НА17-р асуултуудыг асуу. Харин шинжлүүлж байгаагүй гэж хариулсан бол дараагийн асуултыг алгасч, НА18-р асуулт руу оч. Алгассан асуултыг зурж тэмдэглэ. .

**НА16. Танд сорилын үр дүнг хэлсэн үү? Би таны шинжилгээний хариу ямар гарсан бэ гэдгийг сонирхоогүй, харин шинжилгээний хариугаа Та авч байсан эсэхийг сонирхож байна.**

Шинжилгээ өгч байсан хүмүүсийн шинжилгээний дүнг бүү сонирох. Тэгэхээр Та шинжилгээний дүнг сонирхоогүй гэдгийг хариулагчид ойлгуулж хариултаа үнэн зөв авах ёстой. НА17-г үргэлжлүүэн асууж НА18-ыг алгасан НА 19-рүү оч.

**НА18. Та одоо ХДХВ-ын сорил хийлгэхийг хүсвэл хаана очиж өгөхөө мэдэх үү?**

Энэ асуултыг ДОХ өвчин болон түүний нянгийн халдварын талаар ямар нэг хэмжээнд сонсож байсан гэж дээрхи асуултанд хариулт өгсөн хүн бүрээс асууж, хаана шинжилгээ өгч болохыг мэддэг эсэхийг тодорхойлно. Хэрэв хариулагч шинжилгээ өгч байсан бол бид шинжилгээ авдаг газар ойрхон байдаг эсэхийг мэдэх гэж асууж байгааг тайлбарла.

**НА19. HL6-г ШАЛГА:**

**Өрхөд асуулгад хамрагдах 15-49 насны өөр эмэгтэй байна уу?**

Тийм бол дараагийн эмэгтэйгээс асуулга авах, Үгүй бол 5 хүртэлх насны хүүхдийн асуулга руу очно, харин өрхөд судалгаанд хамрагдах 5 хүртэлх насны хүүхэд байхгүй бол тухайн өрхөөс авах судалгааг дуусгана.

### Судалгааны асуулгын маягт. ХХС-3

#### 1. UF. 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН АСУУЛГА

*UF1 – UF8 – р асуултуудыг ярилцлага эхлэхээс өмнө өрхийн асуулгаас авч бөглөнө.*

**UF1. Түүврийн нэгжийн дугаар.** Өрхийн асуулгын НН1-д бичигдсэн кодыг хуулан бичнэ. Хэрэв түүврийн нэгжийн дугаар нэг эсвэл хоёр оронтой тоо байвал тоогоо арын нүдэнд бичиж өмнөх нүднүүдэд “0” цифрийг бичнэ.

**UF2. Өрхийн дугаар.** Өрхийн асуулгын НН2-д бичигдсэн кодыг хуулан бичнэ. Хэрэв өрхийн дугаар нэг эсвэл хоёр оронтой тоо байвал тоогоо арын нүдэнд бичиж өмнөх нүднүүдэд “0” цифрыг бичнэ.

**UF3. Хүүхдийн нэр.** Өрхийн асуулгын “Өрхийн ам бүлийн байдал HL” бүлгийн HL2-оос 5 хүртэлх насны хүүхдийн нэрийг хуулбарлан бичнэ.

**UF4. Хүүхдийг тэмдэглэсэн мөрийн дугаар...** Өрхийн асуулгын “Өрхийн ам бүлийн байдал HL” бүлгийн HL2-оос 5 хүртэлх насны хүүхдийн нэрийг олж түүнд харгалзах HL1-д байгаа дугаарыг бичнэ.

**UF5. Эх/асрагчийн нэр.** Өрхийн асуулгын "Өрхийн ам бүлийн байдал HL" бүлгийн HL2-оос 5 хүртэлх насны хүүхдийн нэрийг олж түүнд харгалзах HL8-д байгаа дугаарыг олно. HL8-д бичигдсэн дугаар нь тухайн хүүхдийн эх/асрагчийн мөрийн дугаар байх бөгөөд түүнд харгалзах нэрийг хуулан бичнэ.

**UF6. Эх/асрагчийн мөрийн дугаар.** Өрхийн асуулгын "Өрхийн ам бүлийн байдал HL" бүлгийн HL2-оос 5 хүртэлх насны хүүхдийн нэрийг олж түүнд харгалзах HL8-д байгаа дугаарыг бичнэ. HL8-д байгаа дугаар нь тухайн 0-5 хүртэлх насны хүүхдийн эх/асрагчийн мөрийн дугаар юм.

**UF7. Ярилцлага авагчийн нэр, дугаар.** Өрхийн асуулгын HH3-д бичигдсэн нэр болон кодыг хуулан бичнэ. Хэрэв ярилцлага авагчийн дугаар нэг оронтой тоо байвал тоогоо арын нүхэнд бичиж өмнөх нүхнүүдэд "0" тоог бичнэ.

**UF8. Ярилцлага авсан он/сар/өдөр.** Ярилцлага хийсэн өдрийг Он/Сар/Өдөр гэсэн дарааллаар тухайн өгөгдсөн зайнд цэвэр, гаргацтай бичнэ. Хэрэв тухайн айлд хэд хэдэн удаа очиж байж судалгаагаа бүрэн авсан бол сүүлийн удаа очсон Он/Сар/Өдөр-г бичнэ.

**UF9. Ярилцлагын үр дүн.** Тухайн асуултад өгөгдсөн хариултын харгалзах кодыг дугуйлна. Хүүхдийн асуулга "UF10-AN5" дуусаад хамгийн сүүлд энэ асуултыг ярилцлага авагч нөхнө. Асуултанд тохирох хариулт байхгүй бол бусад гэдэгт харгалзах "6" гэсэн кодыг дугуйлаад шалтгааныг тодруулж, оновчтой, цөөн үгээр бичнэ.

**UF10. Төрсөн он, сар, өдөр.** Хүүхдийн эх эсвэл асрагчаас нь хүүхдийн төрсөн он, сарыг асууж, өгөгдсөн зайнд бичнэ. Түүний төрсөн сар, өдөр нь нэг оронтой тоо байвал өмнө нь 0 бич. Жишээ нь: төрсөн сар нь гуравдугаар сар байвал 03 гэж бичнэ.

Энд хэрэв эх/асрагч нь төрсөн өдрийг мэдэж байвал он, сар, өдрийг тэмдэглэнэ. Мэдэхгүй байвал 98, 9998-ыг дугуйлна. Хүүхдийн төрсөн сар, өдрийг тодорхой мэдэх нь судалгааны боловсруулалт ялангуяа хүүхдийн вакцинжуулалтанд хамрагдалт болон хүүхдийн биеийн хэмжээсийг тодорхойлоход чухал хэрэгтэйг анхаар.

**UF11. Хэдэн настай вэ?** Өрхийн асуулгын "Өрхийн ам бүлийн байдал HL бүлгийн HL5-аас тухайн хүүхдийн насыг хуулбарлан бичнэ. Хүүхдийн нас 1 оронтой байвал өмнө нь 0 бич.

## 2. BR. ХҮҮХДИЙН ТӨРСНИЙ БҮРТГЭЛ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ОЛГОЛТ

*Энэ судалгааны асуулганд тухайн хүүхдийг төрүүлсэн эх эсвэл түүний асрагчийг 'Хүүхдийн эх' гэж үзнэ.*

**BR 1. (нэр) төрсний гэрчилгээтэй юу? Би гэрчилгээг үзэж болох уу?** Энэ асуулга нь хүүхдийн насыг зөв тодорхойлоход хэрэгтэй, түүнчлэн хүүхдийг төрсөн даруй түүний бүртгэлийг хийдэг эсэхийг тогтооно. Хэрэв төрсний гэрчилгээ байхгүй бол 2-ыг дугуйлна. Төрсний гэрчилгээтэй тэр гэрчилгээг үзсэн бол 1-ийг дугуйлаад, дараагийн 3 асуултыг алгасч, асуулт BR5 руу оч. Харин төрсний гэрчилгээ байхгүй, эх нь хүүхдийнхээ төрсөн сар,



өдрийг зөв хэлж мэдэхгүй тохиолдолд өөр ямар нэг бичиг баримтыг үндэслэн тодруулахыг хичээ. Жишээ нь: Эрүүл мэндийн дэвтэр. Төрсний гэрчилгээ бий гэж хэлбэл гэрчилгээг Та үзээд 1-ийн тоог, гэрчилгээг үзүүлээгүй, гэхдээ гэрчилгээ бий гэж хариулбал 2-ийн тоог дугуйл. Гэхдээ зарим тохиолдолд хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр болон бусад бичиг баримтыг төрснөөс нилээд хожуу бүртгэсэн байж болох учир төрсөн өдрийг тодорхойлохдоо болгоомжтой ханд. Хэрэв төрсний гэрчилгээ байхгүй бол 3-ыг, мэдэхгүй бол 8-ийг тэмдэглэнэ.

Төрсний гэрчилгээ болон бусад бичиг баримт байхгүй, эх нь зөв хариулт өгөх боломжгүй бол цаашдын ярилцлага авах явцад ямар нэг байдлаар түүний төрсөн он, сар, өдрийг тодруулах хэрэгтэй. Эх нь хүүхдийн төрсөн оныг мэдээд харин сарыг нь хэлж мэдэхгүй бол сарыг ямар улиралд хавар, намар гэм мэтээр тодруулан тодорхойлохыг оролд. Хэрэв хүүхдийн төрсөн сарыг тодорхойлж чадаагүй бол хүүхэд жилийн аль улиралд төрсөнийг асуух замаар тодруул. Та хүүхдийн төрсөн оныг заавал бичсэн байна. Хэрэв эх нь хүүхдийнхээ төрсөн оныг санахгүй байвал ямар нэг тэмдэглэлт жил, хуанлийг ашиглах, мөн бусад хүүхдийн төрсөн онтой харьцуулах замаар тодруулах шаардлагатай.

Жишээ нь: *Эх хүүхдийнхээ төрсөн өдөр болон насыг мэдэхгүй бол Энэ хүүхэд хэдэн жилийн өмнө төрсөн бэ? гэж асуу. Та харин тэр хүүхдийн настай уялдуулан, өөр хүүхдийн төрсөн өдөр, төрсөн улирлыг асуух маягаар Хэдэн улирлын өмнө төрсөн бэ? гэж асууж түүнд тусла. Насыг тодорхойлохдоо төрсөн өдрийг үндэслэхийг санаарай.*

**BR 2. (нэр) - ийг төрсөний дараа иргэний бүртгэлийн албанд бүртгүүлсэн үү?**

Төрсний гэрчилгээгүй хүүхдийн хувьд энэ асуултыг асууна. Хэрэв Тийм гэж хариулбал 1-ийн тоог дугуйлж, BR5-р асуултыг асуу. Үгүй гэж хариулбал 2-ийг тоог дугуйлж дараагийн асуултыг асууна. Мэдэхгүй гэж хариулбал 8-ийн тоог дугуйлж, BR4-р асуулт руу шилжих.

**BR 3. (нэр) - ийг төрөхөд нь яагаад албан ёсоор бүртгүүлээгүй вэ?** Энэ асуултаар төрүүлсэн хүүхдээ бүртгүүлдэггүй шалтгааныг тодруулна. Хариултын дагуу кодыг дугуйлна.

**BR 4. Та хүүхдээ яаж бүртгүүлдэгийг мэдэх үү?** Энэ асуулгаар хүүхдийг төрсний дараа хэрхэн яаж, хаана бүртгүүлдэг талаар ойлголт авах зорилготой. Өгсөн хариутын харгалзах кодыг дугуйлна.

**BR 5. UF11-д байгаа хүүхдийн насыг шалга.** Хүүхэд 3 ба түүнээс дээш настай байвал Хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших ямар нэгэн сургалт, цэцэрлэгт хамрагддаг уу? гэсэн асуултыг (BR6) асууна. Бусад тохиолдолд BR8-д очно.

**BR6.** (нэр) сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтанд хамрагдсан уу? Хүүхдийн эх болон асрагч нь сургуулийн өмнөх насны сургалт /цэцэрлэг/ гэдгийг зөв ойлгож байгаа эсэхийг анхаарч тайлбарлаж өгөх хэрэгтэй.

Энэ асуулгаар 5 хүртэлх насны хүүхдүүдээс сургуулийн өмнөх сургалтанд хамрагдаж байгаа байдлыг толдорхойлно. Тийм(1) гэж хариулбал дараагын асуултыг асуу. Хэрэв Үгүй (2) эсвэл Мэдэхгүй (9) гэж хариулбал BR8-руу шилжинэ.

*Судалгааны багийн ахлагч, ярилцлага авагч нар боловсролын хөтөлбөрүүдийн төрлүүдийн талаар /орон нутгийн/ сайн ойлголттой байх хэрэгтэй. Сургуулийн өмнөх боловсролын сургалтанд төрийн болон хувийн цэцэрлэгүүд, зохион байгуулалттай боловсрол олгох хөтөлбөр бүхий сургалтууд /Хүүхэд хөгжлийн төвүүд, өдөр өнжүүлэх гэх зэрэг/ хамаарна.*

**BR 7.** (нэр) сүүлийн долоо хоногт дээрхи сургалтанд хэдэн цаг явсан бэ ? Хэрэв BR6-р асуултанд Тийм (1) гэж хариулсан бол энэ асуулгыг асууж, сүүлийн 7 хоногт нийт хэдэн цаг сургалтанд хамрагдсаныг тодорхойлж цагийн тоог тавина. Цагийн тоо нэг оронтой байвал өмнө нь 0 бичнэ.

**BR 8.** (нэр) – *д сүүлийн 3 өдөр танай өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдээс дараах байдлаар цаг зарцуулсан уу?* “а”-аас “f” хүртэл нийт 6 асуулт тус бүрийн холбогдох хариултыг дугуйлна.

### 3. СЕ. ХҮҮХЭД ХӨГЖИЛ

**СЕ1.** *Танай өрхөд хэдэн ном байдаг вэ?* Тухайн асуулга нь өрхөд байгаа хүүхдэд зориулсан сургуулийн болон энгийн номны тоог мэдэх зорилготой асуугдаж байгаа бөгөөд бага насны хүүхдэд зориулсан зурагтай номыг энэ тоонд оруулахгүй.

Энэ асуултыг тухайн эх/асрагч бүрээс нэг л удаа асууна. Хэрэв та энэ бүлэг асуултыг тухайн өрхийн хэд хэдэн хүүхдийн эх/асрагчаас асууж байгаа бол хамгийн эхний хүүхдийн асуулгыг асууж байхдаа асуултыг нэг удаа тавих бөгөөд дараагийн хүүхэд бүр дээр тохирох хариултыг тодорхойлж бичнэ. Мөн өрхийн нэг буюу түүнээс олон эх/асрагчаас энэ асуултыг асуух тохиолдолд тус бүрээс нь асууна. Учир нь тэдгээрийг хариултууд зөрүүтэй байж болох юм.

Өгөгдсөн зайнд номын тоог бичнэ. Номын бодит тоог гаргах зорилгоор тухайн өрхөд байгаа номнуудыг нэг бүрчлэн тоолох шаардлагагүй зөвхөн хариулагчийн хэлсэн тоог тэмдэглэж авахад хангалттай. Тухайн хариулагч таныг эхний удаа асуухад номын тоог бүрэн мэдэхгүй эсвэл хэлэх боломжгүй бол “10-аас олон ном байгаа юу?” гэж асуугаад “тийм” гэж хариулбал “10” дугуйлна. 10-аас цөөн ном байвал номын бодит тоог 07,08 гэх мэтээр 10 хүртэлх гэсэн хариулын ард тэмдэглэнэ. Хэрэв өрхөд ном байхгүй бол “00”-ыг дугуйлна.

**СЕ2. (нэр)-д зориулсан хэдэн хүүхдийн, зурагтай ном байгаа вэ?** Тухайн асуулга нь өрхөд байгаа бага насны хүүхдэд зориулсан хүүхдийн, зурагтай номын тоог мэдэх зорилготой асуугдаж байгаа бөгөөд сургуулын болон томчуудад зориулсан номыг энэ тоонд оруулахгүй. Сургуулийн болон томчуудад зориулсан номыг өмнө СЕ1-д асуусан.

Өгөгдсөн зайнд номыг тоог тэмдэглэнэ. Номын бодит тоог гаргах зорилгоор тухайн өрхөд байгаа номнуудыг нэг бүрчлэн тоолох шаардлагагүй зөвхөн хариулагчийн хэлсэн тоог тэмдэглэж авхад хангалттай. Нэг бүрчлэн тоолвол илүү их цаг авч мэдэх юм. Тухайн хариулагч таныг эхний асуухад номын тоог бүрэн мэдэхгүй эсвэл хэлэх боломжгүй бол “10-аас олон ном байгаа юу?” гэж асуугаад “тийм” гэж хариулбал “10” дугуйлна. 10-аас цөөн ном байвал номын бодит тоог тэмдэглэнэ. Хэрэв өрхөд ном байхгүй бол “00”-ыг дугуйлна.

**СЕ3. (нэр) гэртээ юугаар тоглодог вэ?** энэ асуултаар хүүхдийн тоглодог тоглоомын ялгаатай төрлүүдийг мэдэх зорилготой. Ер нь хүүхэд дэлгүүрээс худалдаж авсан тоглоомоор тоглодоггүй бол яг ямар төрлийн тоглоомоор тоглох сонирхолтой, тэр нь ямар тоглоом болохыг мэдэх зорилготой. Асуултаа асуугаад хариулт бүрийг дугуйлна. Хариулагч энэ ялгаатай тоглоомын төрлүүдээс ижил хариултыг маш түргэн олох боломжтой. Тэр бүх төрлийг дугуйлж эсвэл нэг ч төрлийг дугуйлахгүй байж болно

Хүүхэд ямар нэг зүйлээр тоглох сонирхолгүй, тоглодоггүй бол “Ү” дугуйлна. “Ү” дугуйлсан бол өөр тоглоомын төрлүүдийг дугуйлаагүй байх ёстой.

**СЕ4. Ер нь хүүхдээ харж байгаа томчуулын хувьд дэлгүүр явах, хувцасаа угаалганд өгөх гэх мэт бусад зайлшгүй шалтгаанаар хүүхдээ өөр хүнд харуулж үлдээдэг. Өмнөх долоо хоногийн тухайн өдрөөс хойш хэдэн удаа хүүхдээ өөр хүүхдээр (10-аас доош насны хүүхэд байна) харуулсан бэ?**

Энэ асуулт нь тухайн хүүхдийг ганцааранг нь үлдээх эсвэл бага насны өөр нэг хүүхдээр харуулахаар үлдээж байгаа эсэхийг мэдэх зориулалттай. Ингэж үлдэх явдал нь хүүхдийг эрсдэлтэй байдалд оруулж байна гэсэн үг юм.

Ярилцлага авч байгаа сүүлийн долоо хоногийн өдрийг оруулж асуултыг тавина. Жишээ нь ярилцлага Мягмар гаригт явагдаж байгаа бол “өнгөрсөн мягмар гаригаас хойш...” хэдэн удаа үлдээсэн гэх мэтээр асууна. Хариултыг тоог өгөгдсөн зайнд бөглөнө. Хүүхдийг тухайн хугацаанд орхиж яваагүй болон өөр хүүхдээр харуулаагүй бол “00” гэж бичнэ.

**СЕ5. (нэр)-ийг өнгөрсөн долоо хоногт хэдэн удаа ганцааранг нь үлдээсэн бэ?** Энэ асуулт нь СЕ4-тэй ижил төрлийн асуулт бөгөөд хүүхдийг өнгөрсөн долоо хоногт ямар нэг харуулах хүүхэдгүйгээр зөвхөн ганцааранг нь үлдээсэн эсхийг мэдэх зорилготой. СЕ4-тэй нэгэн адилаар зөвхөн өнгөрсөн долоо хоногийн тухай асууж байгааг хариулагчид сануулна. Өгөгдсөн зайнд тоог бичнэ. Хэрэв үлдээгээгүй гэж хариулбал “00” гэж бичнэ.

#### 4. VA. "А" АМИН ДЭМИЙН ХЭРЭГЛЭЭ

**VA1. (нэр) “А” амин дэмийг ууж байсан уу?** Энэ асуултаар хүүхэд А амин дэмийг хэрэглэж байсан эсэхийг асууна. Хүүхэд А амин дэм хэрэглэж байсан эсхийг хүүхдийн эхэд сануулахын тулд А амин дэмийн нэг капсулийг үзүүлнэ. (Эхээс зөв хариулт авахын тулд А амин дэмийн хэд хэдэн төрлийн капсулийг үзүүлж болно). Хариултын дагуу зохих кодыг дугуйлна. Хэрэв хүүхдэд А амин дэм хэзээ ч өгч байгаагүй, эсвэл эх / асрагч нь өгсөнийг нь санахгүй байгаа бол холбогдох хариултын кодыг тэмдэглээд дараагийн бүлэг(BF)-т очн.

**VA2. (нэр) сүүлийн тунг хэдэн сарын өмнө уусан бэ?** Хэрэв асуултанд “Тийм” (1) гэж хариулсан тохиолдолд сүүлчийн тунг хэдэн сарын өмнө уулгасаныг тодорхойлж сарын тоог нөхнө. Хэрэв эх нь “Мэдэхгүй” байвал 98 гэсэн кодыг дугуйл.

**VA3. (нэр) сүүлийн тунг хаана уусан бэ?** Энэ асуултаар хүүхэд А витамин тунг хэрэглэх эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тодруулахад ашиглана. Хариултын дагуу кодыг дугуйлна. Хэрэв өгсөн хариулт нь маяганд байгаа хариунуудын дотор байхгүй бол “Бусад” гэсэнд нэрийг нь бичээд 6-ийн тоог тэмдэглэнэ.

## 5. BF. ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТ

**BF 1. (нэр) эхийн сүүгээр хооллож байсан уу?** Хүүхэд эхийн сүүгээр хооллож байсныг асууна. Төрсөн эхийн болон бусад эхийн хөхөөр хооллуулсан, мөн эхийн сүүгээр үгжиж байсныг хөхөөр хооллосон гэж үзнэ. Асуултанд “Тийм” гэж хариулбал 1-гэсэн кодыг дугуйлж BF2 руу очно. Хэрэв “Үгүй” (2) эсвэл “Мэдэхгүй” (8) гэж хариулбал холбогдох кодыг дугуйлж BF3 –ыг асууж эхлэнэ.

**BF 2. (нэр) одоо эхийн сүүгээр хооллож байгаа уу?** Хүүхэд эхийн сүүгээр хооллож байгаа эсэхийг асууна. Эхийн сүүгээр хооллох гэдэгт хүүхэд хөхөөр, болон эхийн сүүгээр угжаар өдөрт нэг удаа хооллодог байсан ч хамаарна. Хариултын дагуу кодыг дугуйл.

**BF 3. (нэр) өнгөрсөн нэг хоногт дараах зүйлээс алиныг нь хэрэглэсэн бэ?**

Өгөгдсөн асуулга бүрээр шалгаж асуу: Амин дэм, эрдэс тэжээл эсвэл эм уусан уу? Буцалсан ус өгсөн үү? гэх мэтээр асуух. Сургалтын явцад суралцаж тодруулсан орон нутгийн хэллэг нэр томъёог хэрэглэвэл зохино. Хариулт болгоны холбогдох кодыг дугуйл. Хэрэв мэдэхгүй гэж хариулбал асуултыг давтан орон нутгийн хэллэгээр ундаа, хоол, гэх мэтээр асууна. Асуулганд жагсаасан хүнсний төрлийн зүйлээс өөр зүйлийг нэрлэбэл “Бусад” гэсэн хэсэгт тодруулж бичээд 1 гэсэн кодыг дугуйл.

**BF 4. Тухайн хүүхэд нухсан болон хагас нухсан хоол идсэн үү?** BF3H шалгаад “Тийм” гэж хариулсан бол дараагийн асуултаас(BF5) үргэлжлүүлэн асууна. Үгүй эсвэл Мэдэхгүй гэж хариулсан тохиолдолд дараагийн бүлэг асуулт (CA)-руу очно.

**BF 5. (нэр) өнгөрсөн нэг хоногт хэдэн удаа шингэн бус нухсан болон хагас нухсан(нухаш, бантан гм) мөн хөнгөн чанарын хоол идсэн бэ?** Хүүхэд шингэн бус нухсан болон хагас нухсан, мөн хөнгөн чанарын хоолыг тухайн өдрөөс хойшхи 7 хоногт хэдэн удаа идсэнийг тодорхойлно. Өнгөрсөн 7 хоног гэдэгт тухайн өдөр 5 дахь өдөр байсан бол өнгөрсөн 7 хоногынх нь 5 дахь өдрөөс тухайн өдөр хүртлэх хугацааг ойлгоно. Хэрэглсэн удаа нь 7- оос олон удаа бол ‘7’ гэж тэмдэглэнэ. Идсэн эсэхийг “мэдэхгүй” бол “8” гэсэн кодыг дугуйлна.

#### **6. СА. ХҮҮХДИЙН ӨВЧЛӨЛ, ЭМЧИЛГЭЭ, СУВИЛГАА**

*Хүүхэд гэдэсний суулгалт өвчин болон өөр ямар нэг төрлийн өвчнөөр өвчилсэнийг мэдэхийн зэрэгцээ ямар эмчилгээ хийж, ямар хоол өгсөнийг тодорхойлоход энэ асуулгын гол зорилго оршино. Өдөрт 3 ба түүнээс дээш удаа усан шингэн алдаж байгааг суулга өвчин гэнэ.*

**СА1. Сүүлийн 14 хоногт (нэр) гэдэс нь өвдөж суулгаж, гүйлгэсэн үү?** Эхийн өгсөн хариултын дагуу холбогдох кодыг дугуйлна. Харин эх нь хүүхэд суулгасан эсэхэд эргэлзэж байвал хүүхэд өдөрт 3-аас доошгүй удаа шингэн алдаж байвал суулгалт гэнэ гэдгийг ойлгуул. Түүнчлэн сүүлийн 14 хоногт ярилцлага авч байгаа өдрөөс эхлэн өмнөх 14 хоногийг хамруулна. Хэрэв хүүхэд сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн байвал. 1 гэсэн кодыг дугуйлаад дараагийн асуултад очно. Харин сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвдөөгүй бол 2 гэсэн кодыг, эсвэл өвдсөн эсэхийг мэдэхгүй бол 8 гэсэн кодыг дугуйлж, СА5-р асуулт руу очно.

**СА 2. нэр суулгалт өвчнөөр хамгийн сүүлд өвчлөхдөө доорхи шингэн зүйлсээс уусан уу?** Энэ өвчний үед хүүхэд юу голдуу ууж, хэрэглэдгийг энэ асуултаар тодруулах зорилготой. Шингэн сэлбэх давсаар бэлдсэн шингэн өгсөн үү? гэх мэтээр асуулт СА2А, СА2В, СА2С бүрийг тус тусад нь асууж. Хариултын кодыг дугуйлна.

**СА 3. Хүүхэд өвчтэй байх үедээ шингэнийг ямар хэмжээгээр уусан бэ?** Суулгалт өвчний үед хүүхэд ердийнхөөс хэд дахин их шингэн ууж болох юм. Бид өвчлөх хугацаанд хүүхдийн шингэний хэрэглээ өөрчлөгдөж байгаа эсэхийг мэдэх зорилготой. Хүүхдийн хэрэглэсэн шингэний хэмжээг эх, асрагчаас асууж үндэслэлтэй хэмжээг хэлүүлж авах. Шингэнд зөвхөн өвчинтэй холбогдож ууж байгаа /жишээ нь: шингэн сэлбэх давсаар хийсэн уусмал/ бус тэр үед хэрэглэсэн бүх төрлийн шингэн зүйлс, тухайлбал цай, шүүс, гэх мэт хамаарна. Хүүхдийн өвчтэй байх үед хэрэглэсэн зүйлийг эх асрагчийн хэлснээр бус тухайн үед бодит байдлаар юу хэрэглэсэн гэдгийг тогтоохыг хичээ, Танай хүүхэд өвчтэй байхдаа хэдий хэмжээний шингэн ууж байсан бэ? гэж асуух. Үүнийг хөхөөр хооллож байгаа

хүүхдийн хувьд тодорхойлоход хэцүү. Гэхдээ хүүхдийн эх асрагч ойролцоогоор тодорхойлох боломжтой. Хариултын кодыг дугуйлна.

**СА 4. Хүүхэд өвчтэй байх үедээ хоолоо (хэвийн хэмжээнээс) хэр зэрэг идэж байсан бэ?** Сүүлгалт олон бусад өвчний үед хүүхдийн идсэн хоолны хэмжээ ердийнхөөс өөрчлөгдөж болох юм. Энэ асуултыг зөвхөн маягтанд байгаа үгээр асуу. Асуултыг уншиж, асуугаад өгсөн хариултын кодыг дугуйлна. Хүүхэд ердийнхөөс бага хоол идсэн гэвэл бага эсвэл их гэдэг нь хир зэрэг хэмжээ вэ ? гэж лавлаж асуу. Хийн хариулснаар тодорхойлж кодыг дугуйл. Хүүхэд хэвийн үедээ хэдий хэмжээний хоол идэж байсаныг асууж тодруулна. Хүүхэд нялх хэт бага, зөвхөн хөхөөр хооллодог гэж эх хариулсан тохиолдолд дахин лавлаж асуух шаардлагагүй. Ууж, идэж байгаа гэдгээр ойлгоно.

### **ШИНГЭН СЭЛБЭХ ДАВСЫН ХАНГАМЖ, ЗАРДАЛ**

Энд тухайн хүүхэд шингэн сэлбэх давс хэрэглэсэн бол хаанаас, ямар үнээр авсаныг тодруулах зорилготой.

**СА 4А. Шингэн сэлбэх давс хэрэглэсэн үү?** СА2А шалга. “Тийм” бол дараагийн асуултаас(СА 4В) үргэлжлүүлэн асууна. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд СА5-руу очно.

**СА 4В. Шингэн сэлбэх давс хаанаас авсан бэ?** Энэ асуулт нь шингэн сэлбэх давс авч хэрэглэсэн бол хаанаас авсаныг мэдэх зорилготой. Шингэн сэлбэх давсыг тухайн өгөгдсөн хугацаанд хэд хэдэн удаа худалдаж авсан бол сүүлийн авалтыг л асууна. СА 4А-д “Тийм” гэж хариулсан байвал асууна. Маягтад байгаа хариултаас өөр хариулт хэлсэн тохиолдолд тодруулж бичээд 96-г дугуйлна. Мэдэхгүй гэж хариулбал 98-г тэмдэглэнэ.

**СА 4С. Та ямар үнээр авсан бэ?** Энэ асуулт нь шингэн сэлбэх давс авч хэрэглэсэн бол ямар үнээр авсанг мэдэх зорилготой. (СА 4А)-д “Тийм” гэж хариулсан хүмүүсээс энэ асуултыг асуухыг анхаар. Худалдаж авсан үнийн дүнг өгөгдсөн нүдэнд төгрөгөөр бичнэ. Авсан үнийн дүн 4 -өөс цөөн оронтой бол өмнөх хоосон нүдэнд “0” бичнэ. Шингэн сэлбэх давсыг үнэгүй авсан бол 9996-г, худалдаж авсан үнийн дүнг мэдэхгүй бол 9998-ыг дугуйлна.

**СА 5. Сүүлийн 14 хоногт хүүхэд ханиалгаж байсан уу ?** Ханиалгаж өвчилсөн гэдэг нь ханиад хүрч, халуурсан тохиолдол юм. Хэрэв эх асрагч нь хүүхдийг үргэлж ханиалгаж байдаг, эсвэл Тэр сар гаруй ханиалгаж байна гэж хариулбал “Тийм” (1) гэж үзнэ. Хэрэв ханиалгаж, өвдөөгүй (2), эсвэл Мэдэхгүй (8) гэж хариулсан тохиолдолд холбогдох кодыг дугуйлж, асуулт СА12-рүү очих. Энэ өвчин нь эрт эхлээд одоог хүртэл үргэлжилж байгаа бол “Өвчтэй” гэж үзнэ.

**СА 6. Энэ өвчний үед хүүхдийн чинь амьсгаа хэвийнхээс өндөр, аль эсвэл амьсгалахад хүнд байсан уу?** Энэ асуултаар хүүхэд эмнэлгийн тусламж авахаар түвшинд өвдсөн эсэхийг тогтооно. Ойрхон, хурдан амьсгална гэхийг юу гэж ойлгох вэ гэж асрагч асуувал ердийн үеийнхээс мэдэгдэхүйц хурдан амьсгалж байхыг хэлнэ гэж тайлбарлаж өг. Хариултын дагуу холбогдох кодыг дугуйл. Хэрэв амьсгал нь түргэсээгүй (2) эсвэл “Мэдэхгүй” (8) гэж хариулсан тохиолдолд холбогдох кодыг дугуйлж, асуулт СА12-рүү оч.

**СА 7. Амьсгал түргэссэн нь ханиад цээжийг нь барьсанаас уу, эсвэл хамар нь битүүрсэнээс болсон уу?** Энгийн ханиад, томуу биш нилээд хүндэрсэн тохиолдлыг тодруулна. Цээжний хөндийд өвчилсөн бол 1, Хэрэв хамар битүүрч өвчилсөн бол 2, цээжний хөндий болон хамрын хэсэгт хамт өвчилсөн бол 3 гэсэн кодыг дугуйлна. Дээрхээс өөрөөр хариулбал “Бусад” -д хамруулж 6 гэсэн кодыг дугуйлах ба юу өвчилсөнийг тодруулж бичнэ. Хаана, юу өвчилсөнийг мэдэхгүй гэвэл 8 гэсэн кодыг дугуйлна. 2 болон 6 гэсэн кодыг дугуйлсан тохиолдолд СА12-рүү очих.

**СА 8. Хүүхдээ эмчлэхийн тулд хэн нэгэн гадны хүнээс зөвлөлгөө, тусламж авсан уу?** Энд өвчилсөн үед бусдаас (гэрээс гадуур) зөвлөлгөө авч, эмчилгээ хийлсэн тухай асуух бөгөөд үүнд гэрээсээ гадуур мэргэжлийн эмч, бариач, лам, хуврагт үзүүлэх гэх мэтээр бусдаас зөвлөлгөө авах, эмчилгээ хийлгэхийг хамруулна. Түүнчлэн мэргэжлийн эмч, бусад хүмүүс дуудлагаар гэрт нь ирж эмчилгээ хийж, зөвлөлгөө өгсөн бол гэрээс гадуурхи үйлчилгээнд хамрагдана. Мөн хүүхдийн эх, асрагч (Жишээ нь эх асрагч хүүхдийг дагуулалгүйгээр эмийн сан руу явж шаардлагатай эмийг авчирах.) эмнэлэгт очиж холбогдох эм, эмчилгээ тариаг авчирч хэрэглэж байвал гэрээс гадуурхи үйлчилгээнд хамруулна. Хэрэв тусламж зөвлөлгөө авсан бол 1 –ийг, зөвлөлгөө, тусламж аваагүй бол (2)-ыг, Мэдэхгүй гэж хариулбал (8)-ыг дугуйлж, асуулт СА10-рүү очно.

**СА 9. Хүүхдээ өвчлөхөд хаана үзүүлж, зөвлөлгөө, тусламж авсан бэ?** Хариулагч санаагаа төвлөрүүлэхийг хүлээ, түүний хариултанд туслаж ямар нэг санаа хэлж өгч болохгүй. Энд хэд хэдэн хариултыг дугуйлж болно. Өгсөн хариултын дагуу холбогдох үсэг бүрийг дугуйл. Хэрэв маягтад тусгагдаагүй хариулт өгсөн бол “Бусад” гэдэгт бичиж үсгийг дугуйлна.

**СА 10. Хүүхдийнхээ өвчнийг эмчлэхийн тулд эм уулгасан уу?** Энд өвчилсөн үед эдгээхийн тулд ямар нэг эм уулгасан эсэх талаар ярьж байна. Эм уусан тохиолдолд 1-ийг дугуйлж дараагийн асуултыг асууна. Харин эм уугаагүй, эсвэл Мэдэхгүй гэж хариулбал зохих кодыг дугуйлж СА12-луу шилжинэ.

**СА 11. Ямар эм уулгасан бэ?** Энд хүүхдийнхээ өвчнийг эмчлэхийн тулд ямар нэг эм уулгасан, СА10-р асуултанд 1-ийг дугуйлсан хүмүүсээс тухайн эм нь ямар төрлийн эм болохыг тодруулах зорилготой асууж байгаа хариулагчийн хэлсэн эм бүрийн харгалзах үсгийг дугуйлна. Маягтанд байгаагаас өөр эм уулгасан бол “бусад” -д тодруулж бичээд “Х” үсгийг, ямар эм уулгасанаа мэдэхгүй бол “Z” үсгийг дугуйлна.

#### **ХАТГААНД ЗОРИУЛЖ АВСАН АНТИБИОТИКИЙН ХАНГАМЖ, ЗАРДАЛ**

Энд тухайн хүүхдийн хатгаанд зориулж антибиотик хэрэглэсэн бол хаанаас, ямар үнээр авч хэрэглэснийг тодруулах зорилготой.

**СА 11А. Ямар нэгэн антибиотик авсан уу?** СА11 шалга. “Тийм” бол дараагийн асуултаа(СА 11В) үргэлжлүүлэн асууна. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд СА12-руу очно.

**СА 11В. Антибиотик хаанаас авсан бэ?** СА 11А-д “Тийм” гэж хариулсан тохиолдолд асууна. Хэд хэдэн удаа худалдаж авсан бол сүүлчийн тухай асуух бөгөөд нэг л кодыг дугуйлна. Маягтад бичсэн хариултаас өөр хариулт хэлсэн тохиолдолд тодруулж бичээд харгалзах 96 кодыг дугуйлна. Мэдэхгүй бол 98-г тэмдэглэнэ.

**СА 11С. Антибиотикийг ямар үнээр худалдаж авсан бэ?** Энэ асуулт нь антибиотик авч хэрэглэсэн бол ямар үнээр авсаныг мэдэх зорилготой. Мөн энд антибиотикийн нэгжийн үнэ биш худалдан авч хэрэглэсэн үнийн нийт дүнг бичнэ. СА 11А-д тийм гэж хариулсан хүмүүсээс асууна. Худалдан авахад зарцуулсан мөнгийг төгрөгөөр бичих бөгөөд дүнг нь 4 - өөс цөөн оронтой бол өмнөх хоосон нүхэнд “0” бичнэ. Шингэн сэлбэх давсыг үнэгүй авсан бол 9996 –г, харин худалдаж авсан үнээ мэдэхгүй бол 9998-г дугуйлна.

**СА 12. Танай хүүхэд 3 хүртэлх настай юу?** UF11-г шалгаж үзнэ. Тухайн хүүхэд 0-3 настай бол асуулт СА13-аас үргэлжлүүлэн асууна, хэрэв 4-5 настай бол СА14-рүү очно.

**СА 13. Хүүхэд хамгийн сүүлд шингэн алдахад ялгадасыг яаж зайлуулсан бэ?** Энэ асуултыг СА12-д “Тийм” гэж хариулсан тохиолдолд асууна. Зөвхөн нэг хуриултын кодыг дугуйлна. Мөн нэр зааснаас өөр газарт ялгадасыг зайлуулдаг бол “бусад” гэсэн хэсэгт тодруулан бичээд 96-г дугуйлна. Мэдэхгүй бол 98-ыг дугуйлна.

**СА 14. Та ямар тохиолдолд, өвчний ямар шинж тэмдэг илрэхэд хүүхдээ эмнэлэгт яаралтай үзүүлдэг вэ?** Заримдаа хүүхэд хүндээр өвчилж түүнийг эмнэлэгт яаралтай үзүүлэх шаардлага гардаг. Энэ асуултыг хүүхдийн эх асрагчаас нэг л удаа асууна. Хэрэв 5 хүртэлх насны хэд хэдэн хүүхэд байвал эхний хүүхдийн асуулгын хуудсыг нөхөөд бусад хүүхдийн хувьд эх болон хүүхдийн асрагчын бөглөхгүй зурж тэмдэглэнэ. (Өөрөөр хэлбэл



зөвхөн нэг хүүхэд дээр л энэ асуултыг асуух нь хангалттай). Дээрхи гол шинж байдлыг хэлж байх үед тэдний яриаг бүү саатуул. Өөр ямар шинж тэмдэг байх вэ гэж үргэлжлүүлэн асууж энэ асуултанд Та хангалттай хариулт авах хэрэгтэй. Хэрэв тэдний хэлж байгаа шинж тэмдгүүд нь Таны санаатай тохирохгүй бол хамгийн чухал нь гэсэн хариултыг дугуйл, гэхдээ хэлж байгаа шинж тэмдэгийн тодорхойлолтыг бүрэн тэмдэглээд дараа нь түүнийгээ багийн ахлагчтайгаа хамтран тодруулж, хянана.

## **7. IM. ВАКЦИНЖУУЛАЛТ**

*Энэ бүлгийн асуулгаар 5 хүртэлх насны хүүхдийн сахуу татран, хөхүүл ханиад, сүрьеэ, татран, улаан бурхан, халдварт шар өвчний дархлаажуулалтын вакцинд хамрагдсан түвшинг тодорхойлно.*

**IM 1. Танай хүүхдэд вакцин хийлгэсэн бүртгэл, карт бий юу?** Хэрэв “Бий” гэж хариулбал бүртгэлийн картыг үз. Хэрэв хүүхдийн эх бүртгэлийн картыг олохгүй бол ийм бүртгэл өөр хаана байхыг асууна. (*Жишээлбэл харьяаллын эмнэлэгт байж болно*).

**IM 2-8.** Дээрхи бүх тарилгыг хийлгэсэн хугацаа, хэмжээг карт, бүртгэлээс хуулан бич. *BCG (сүрьеэгийн вакцин- хүүхэд төрсөний дараа 24 цагийн дотор хийдэг, тариулсны шинж тэмдэг нь хүүхдийн гарын зүүн мөрөнд сорви тогтсон байдаг).*

Тарилгын бүртгэлийг маш анхааралтай үз. Зарим тохиолдолд нэг дор бүртгээгүй байж болно. Түүнчлэн тарилга хийлгэсэн сар, өдрийн байрыг сольж бичсэн байж болохыг анхаар. Асуулт 6-гаар эрүүл мэндийн дэвтрээс нийт хэдэн төрлийн вакцин хийснийг харж болно. Хэрэв дээрхи вакцинууд хийгдсэн байвал Тарилгыг тэмлэглэсэн карт, дэвтэр байхгүй тохиолдолд хүүхдэд вакцин хийлгэсэн боловч эрүүл мэндийн дэвтэр, карт дээр нь бүртгээгүй байсан уу гэж асуу. Дэвтэрт сар, өдөр бичигдээгүй бол "44" гэж бич. Эрүүл мэндийн дэвтэргүй хүүхдийн хувьд 1-6 -р асуултыг алгас. Харин эрүүл мэндийн дэвтэр, карттай хүүхдийн хувьд бүх холбогдох зүйлийг хуулж дууссаны дараа 6-р асуултыг асуу. Хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, картаас үзэхэд хүүхэд урьдчилан сэргийлэх тарилгыг бүрэн хийлгэсэн байвал энэ хүүхдийн карт нь дээр тэмдэглэлгүйгээр нэмэлт тарилгыг хийлгэж байгаа эсэхийг асууна. Тухайн хүүхдийн вакцинд хамрагдсан эсэхийг тодруулахад дараах хүснэгтийг ашиглаж болно.

Вакцинжуулалт

Вакцины нэр	Төрсний дараа 24-48 цагт нь багтааж	2 сартайд нь	3 сартайд нь	4 сартайд нь	8-11 сартайд нь	1 настайд нь	2 настайд нь	8 настайд нь	15 настайд нь
Сүрьеэ	BCG								
Халдварт саа	OPV0	OPV1	OPV2	OPV3					
В гепатаит									
Сахуу, хөхүүл ханиад, татран /гуравт/		DPT1	DPT2	DPT3					
Сахуу татран /хоёрт/									
Улаан бурхан									

**IM 9. Картан дээр бүртгэгдсэн вакцинаас гадна (нэр)-д өөр төрлийн вакцин хийсэн үү?** Жишээ нь Үндэсний вакцинжуулалтын өдөрөөр зэрэг нийтийг хамарсан өдөр вакцин хийлгэсэн байж болно.

Энэ асуултыг зөвхөн хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр нь байгаа тохиолдолд л асууна. Учир нь зарим тохиолдолд хүүхдийн хийлгэсэн тарилгыг дэвтэрт бичээгүй байж болдог. Жишээ нь эх нь эмнэлэг, очихдоо эсвэл Үндэсний дархлаажуулалтын өдөрт оролцохдоо эрүүл мэндийн картыг нь мартаад авч очоогүй байж болох юм.

Хэрэв өөр төрлийн нэмэлт тунг хэрэглэсэн үү гэхэд `Тийм` гэж хариулсан бол дараагийн асуултыг алгасч, асуулт IM11-ыг асуу. “Үгүй”, “Мэдэхгүй” гэж хариулсан тохиолдолд IM19-д очих. Эрүүл мэндийн дэвтэр дээр бичсэн нэмэлт тунг харна. Жишээ нь (сахуу, хөхүүл ханиадны DPT 2) тунг хэрэглэсэн гэж эрүүл мэндийн дэвтэр дээр бичигдсэн, бусад нь бичигдээгүй байвал асуулт (DPT) 3 – н өдөр гэсэн мөрөнд “66” гэж бичээд сар, жилийн хоосон үлдээнэ. Сүрьеэгийн тарилга хийлгэсэн гэсэн бүртгэлтэй байвал асуулт 8-д нэмэлт тунг хэрэглээгүй гэж бичиж болох юм. Эрүүл мэндийн дэвтэр байхгүй бол урьдчилан сэргийлэх тарилганд хамрагдсан хэмжээг тогтоохын тулд 10-19-р асуултыг асууна. Хэрэв шаардлагатай бол хүүхдийн эх эсвэл асрагчаас хүүхдийн вакцинжуулалтын талаар тодруулж асуух, ингэж ярилцахдаа орон нутгийн хэллэгийг хэрэглэ. Бид тодорхой өвчний халдваржилт, түүнд хэрэглэх эм, тариа, өвчний эсэргүүцлийн талаар сонирхоогүй зөвхөн урьдчилан сэргийлэх тарилгын талаар ярилцаж байгааг сана.

**IM 10. (нэр) өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ер нь вакцин хийлгэсэн үү?**

Үндэсний вакцинжуулалтын өдрөөр г.м. Судалгааны асуулганд хариулагч зөвхөн эрүүл мэндийн дэвтэр байхгүй бол асуултыг уншиж өг. Хэрэв Үгүй (2) эсвэл Мэдэхгүй (8) гэж хариулсан бол Асуулт IM15-д очно.

**IM 11. (нэр) сүрьеэ өвчний эсрэг (BCG) вакцин хийлгэж байсан уу?**

Холбогдох кодыг дугуйл. Хэрэв хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт сүрьеэгийн вакцин (Асуулт 2) хийлгэсэн гэж тэмдэглэсэн байхад Үгүй нэмэлт тун хэрэглээгүй гэж хариулсан байж болохыг анхаар. Энэ вакцин нь хүүхдийн гар болон мөрөн дээр сорви үүсгэдэг болохыг анхаар.

**IM 12. (нэр) саагийн эсрэг вакцин дуслуар уулгасан уу?**

Холбогдох кодыг дугуйл. Хэрэв Тийм (1) гэж хариулсан бол дараагийн асуултыг асуу. Харин Үгүй (2) эсвэл Мэдэхгүй (8) гэж хариулбал IM15-р асуултыг асуу. Хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт саагийн вакцины тунгийн хэмжээг бичээгүй бол лавлан асуух хэрэгтэй.

**IM 13. (нэр) саагийн эсрэг вакцины эхний тунг уухад хэдэн настай байсан бэ?**

Хүүхэд төрсний дараахан эсвэл арай хожуу өгсөн үү? Холбогдох кодыг дугуйл.

**IM 14. (нэр) саагийн эсрэг вакциныг хэдэн удаа уулгасан бэ?**

Тоог бич. Эрүүл мэндийн дэвтрээс харж, 1-9 удаа уулгасан бол тоог бичихдээ өмнө нь заавал “0” бичнэ.

**IM 15. Татран, хөхүүл ханиалга (DPT) сахуугийн эсрэг урьдчилан сэргийлэх тарилгуудыг хүүхдийн хонгонд нь тарьсан уу?**

Холбогдох кодыг дугуйл. Хэрэв тийм (1) гэж хариулсан бол дараагийн 15-р асуултыг харин үгүй (2), эсвэл мэдэхгүй (8) гэж хариулсан бол 17-р асуултыг асууна.

**IM 16. Дээрхи вакцинаар хэдэн удаа тариулсан бэ?**

Эрүүл мэндийн дэвтэрт вакцины тунгийн хэмжээг бичсэн байх ёстой учир дэвтрээс харах. 1-9 удаа уулгасан бол тоог бичихдээ өмнө нь заавал “0” бичнэ.

**IM 17. (нэр)-ийг 9 сар буюу түүнээс дээш сартай байхад нь улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин (урьдчилан сэргийлэх тариа) гарт нь тарьж байсан уу?**

Эрүүл мэндийн дэвтэрт улаанбурхан өвчний вакцины тарилгыг бүртгэсэн (Асуулт IM6-д) байвал энэ асуултанд нэмэлт тунг аваагүй гэж болно.

Улаанбурхан өвчний вакциныг голдуу хүүхдийн гарт тариагаар хийдэг. Зарим тохиолдолд хүүхдийн хонго, гуяны хэсэгт тарьдаг. Хүүхдийн эх улаанбурханы вакциныг хийлгэсэн гэж байвал гуяны хэсэгт тарилгын соривыг үзэж хариулт тохирч байгааг хянах.

**IM 18. (нэр)-ийг 9 сар буюу түүнээс дээш сартай байхад нь чичрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин (урьдчилан сэргийлэх тариа) гарт нь тарьж байсан уу?**

Эрүүл мэндийн дэвтэрт чичрэг өвчний вакцины тарилгыг бүртгүүлсэн (Асуулт IM7-д) байвал энэ асуултанд нэмэлт тунг аваагүй гэж болно. Чичрэг өвчний эсрэгвакциныг голдуу хүүхдийн гарт тарьдаг. Заримдаа хүүхдийн хонго, гуяны хэсэгт тарьдаг. Хүүхдийн эх чичрэг өвчний вакциныг хийлгэсэн гэж байвал тарилгын соривыг үзэж хариулт тохирч байгааг хянах.

**IM 19. (нэр)-д үндэсний вакцинжуулалтын өдөр вакцин хийлгэж байсан уу?**

Холбогдох кодыг дугуйл. ҮВӨ-г хаана, ямар улиралд зохион байгуулсаныг тодотгож өгөх нь зарим эхчүүдэд тэр өдрийг санахад тус болно./Манай улсад жил бүрийн 5-р сарын 10-нд, 10-р сарын 10 нд энэ ажлыг зохиодог/. Зарим улс орнуудад вакцины бүртгэлийн дэвтэрийг эрүүл мэндийн газарт байгаа тохиолдолд эрүүл мэндийн газарт очиж картаас асуултыг бөглөнө.

**IM 20. 5-аас доош насны өөр хүүхэд байна уу?** Өрхийн нэрсийн жагсаалтын асуулт HL8 баганыг шалга. 5-аас доош насны өөр хүүхэд байвал энэ асуулгыг дуусгаад “ТАВААС ДООШ НАСНЫ ХҮҮХДИЙН ТАЛААРХИ АСУУЛГА”-ыг нөхнө. 5 аас доош насны хүүхэд байхгүй бол тухайн асуулга дуусгана. Энэ хүүхэд тухайн айлын суулчийн 5 аас доош насны хүүхэд байвал “ХҮҮХДИЙН ӨСӨЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ” гэсэн бүлгийн асуултыг асууна.

## **8. АН. ХҮҮХДИЙН ӨСӨЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Судалгаанд хамрагдсан хүүхэд бүрийн биеийн жин урт, өндрийг хэмжиж дүнг нөхсөн байна. Хүүхдийг жигнэх зааврын дагуу хүүхдийн биеийг хэмж. Хэрэв шаардлагатай бол хүүхдийг хэмжих үед эхийг туслалцуулж болно. Хүүхдийг нүцгэн байхад нь буюу хувцасгүйгээр хэмжинэ. Хэрэв энэ нь боломжгүй бол хүүхдэд өмсгөсөн хувцасыг нэг бүрчлэн тусад нь хэмжиж тэмдэглэх хэрэгтэй. Ж: оймс, гутал, шаахай, дотуур хувцас г.м.

Судалгаанд хамрагдаж байгаа өрхийн хүүхдүүдийн талаархи асуулгыг бүрэн авч дууссаны дараа хүүхдийн биеийг хэмжинэ. Хэрэв тухайн өрхөд судалгаанд хамрагдах хүүхэд хэд хэд байвал нэг хүүхдийн биеийн жин, өндөр, уртыг хэмжиж дууссаны дараа дараагийн хүүхдийг хэмжинэ. Түүнчлэн өрхөд судалгаанд хамрагдвал зохих насны хүүхдүүдтэй хэд хэдэн эх байвал эхлээд нэг эхийн хүүхдүүдийн талаархи асуулга, хэмжүүрийг дуусгасны дараа дараагийн эхийн хүүхдүүдийг хэмжинэ.

*Хүүхдийг жигнэж, хэмжиж байхдаа хүүхдийг сайтар харж хяна. Гэхдээ хүүхдийг сайн, барьцтай барих ба харин хүүхдэд эелдэг дөлгөөн харьцах хэрэгтэй. Тайван бай. Хүүхэд*

болон хүүхдийн эх танд итгэсэн байх ёстой. Хүүхдийг хэмжүүрийн багаж хэрэгсэлтэй ганцааранг орхиж болохгүй. Эх болон хүүхдэд хүүхдийг хэмжихэд ямарч айх, санаа зовох зүйл байхгүй гэдгийг тайлбарлаж тэдний зовиурыг арилгахад тусла. Заримдаа бага хүүхдүүд маш дургүйцдэг. Хэрэв хүүхдийн эх нь татгалзаж байгаа эсвэл хүүхэд өвдсөн тохиолдолд хүүхдийг хэмжиж жигнэж болохгүй.

**АН 1. Хүүхдийн жин. Кг** Сургалтын үед өгсөн зааврын дагуу хүүхдийн биеийн жинг хэмжих хэрэгтэй. Биеийн жинг 100 граммын нарийвчлалтайгаар, кг-аар бичнэ. Гэхдээ КГ-аас хойш граммыг аравтын орны нарийвчлалтай ав. Хэрэв КГ-ын хэмжээ нэг оронтой тоогоор бичигдэх бол урд нь 0 тавина. Жишээ нь: 03.5 кг.

**АН 2. Хүүхдийн урт (өндөр). см.** Хүүхдийн насыг UF1-с шалгана. 2 хүртэлх насны хүүхдийн уртыг хэвтээгээр нь сантиметрээр хэмжинэ. Хэрэв хүүхэд 2 болон түүнээс дээш настай байвал хүүхдийг зогсоож өндрийг нь хэмжинэ. Урт, өндрийн хэмжээг сантиметрээр хэмжих ба хоёр оронтой тоогоор бичигдэхээр болбол урд нь 0 тавина.

**АН 3. Хэмжилт хийсэн тоологчийн хувийн дугаар.** Хүүхдийн биеийг хэмжсэн хэмжигчийн хувийн дугаарыг бичнэ. Нэг оронтой тоо байвал өмнө нь "0"-г бичнэ.

**АН 4. Хэмжилтийн үр дүн.** Хэмжүүрийг бүрэн хийсэн эсвэл хийгээгүй талаархи үндсэн шалтгааныг тодорхойлж, хариултын холбогдох шифрийг дугуйл. Өгөгдсөн хариултаас өөр шалтгаан гарсан бол бусад гэсэн хэсэгт бичээд 6- г дугуйлна.

**АН 5. Хэмжилтэнд хамрагдах ёстой өөр хүүхэд байгаа юу?**

Хэмжилтэнд хамрагдах өөр хүүхэд байвал дараагийн хүүхдийг хэмжиж, бичлэгийг хий. Хэрэв үлдэж, хоцорсон хүүхэд байхгүй бол асуулгыг дуусгана.

*Ярилцлага авч дууссан бол өрхийн гишүүдэд талархалаа илэрхийл. Тухайн өрхөөс явахын өмнө энэ өрхийн бүх ярилцлага өгөгчийн тоо нь Өрхийн асуулгын мэдээлэлтэй тохирч байгаа эсэх, маягтыг бүрэн нөхсөн эсэх, нэг ч асуултын хариуг хоосон орхиогүй эсэхийг шалга. Зөвхөн 0 гэсэн хариулт болон асуулгүй орхисон мэдээлэл эсвэл мэдэхгүй гэж өгсөн хариулт болон маягтанд байгаа хариултаудын хоорондын ялгаа, уялдааг үз.*

Судалгааны нөхсөн асуулгын хуудас дарааллын дагуу байгаа, эсхийг шалгаад иж бүрэн болгож ахлагчид хүлээлгэн өгнө.

Үндэсний статистикийн газар. 2005 он